**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН**
**“ЭНГИЙН НАЙРЛАГАТАЙ ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХ”**
**ТӨСЛИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ**
**МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 2550466

2022 он

# БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА....3
ХАЯГИЙН ХЭСЭГ....3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ....5
БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ....6
ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ....8
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ....15
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ...16
I. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө....16
II. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө....17
III. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө....17
IV. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө....17
V. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө....17
VI. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө....17
VII. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө....19
VIII. БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө....20
IX. БОМТ-ний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө....21
X. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр....21
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР....22
**Дүгнэлт ....24**

**Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1. Усны нийт хэрэглээ....6
Хүснэгт 2. Байгаль орчны шинжилгээ....11
Хүснэгт 3. Нөлөөллийн магадлан жагсаах аргын матриц....13
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө....14
Хүснэгт 5. Мониторингийн цэгийн координат....19

**Зургийн жагсаалт**

Зураг 1. Тэсрэх бодисын үйлдвэрийн талбайн байршлын тойм зураг....4
Зураг 2. Энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын бүтэц....5
Зураг 3. Үйлдвэрийн обьект болон хиймэл дагуулын мэдээ....8
Зураг 4. Тэсрэлтийн үеийн нөлөөллийн бүс....9
Зураг 5. Нөлөөлөл буурах функцээр тооцоолсон төслийн нөлөөллийн бүс (Нөлөөллийн эрчим 10 бол хүчтэй, 20 бол дунд, 30 бол бага)....11
Зураг 6. Дээж авах цэгийн байршил....18

# ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

## ХАЯГИЙН ХЭСЭГ

| № | ҮЗҮҮЛЭЛТҮҮД | | |
|---|---|---|---|
| 1. | Аж ахуйн нэгжийн нэр | | “Монголросцветмет” ТӨҮГ |
| 2. | Улсын бүртгэлийн дугаар | | 9019029071, регистр 2550466 |
| 3. | Үйлдвэрийн нэр | | Бор-Өндөр УБҮ |
| 4. | Ордын нэр | | Бор-Өндөр, Адаг |
| 5. | ордын байршил | нийслэл/ хот/ аймаг | Хэнтий |
| 6. | | сум/дүүрэг | Бор-Өндөр |
| 7. | Ашигт малтмалын төрөл | | УБҮ-ийн тэсэлгээний материалыг хадгалах |
| 8. | Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар | | MV-000173, MV-000174 |
| 9. | Ашиглалт эхэлсэн огноо | | 1981 |
| 10. | Аж ахуйн нэгжийн хаяг | Аймаг/хот | Хэнтий аймаг |
| 11. | | Сум/дүүрэг | Бор-Өндөр. |
| 12. | | Баг/хороо | Холбоо-1 |
| 13. | | Гудамж/байр | Үйлдвэрийн район |
| 14. | | Шуудангийн хайрцаг | Хэнтий, Бор-Өндөр 213722 |
| 15. | | Утас | 70567148 |
| 16. | | Факс | 70567 507 |
| 17. | | Гар утас | 80898194 |
| 18. | | Электрон шуудан | Bor-undur@monros.mn |
| 19. | | Вэб хуудас | Bor-undur@monros.mn |
| 20. | Захирлын хаяг | Нэр | Б.Магсаржав. |
| 21. | | Утас | 70567-148 |
| 22. | | Факс | 70567-507 |
| 23. | | Электрон шуудан | Bor-undur@monros.mn |
| 24. | ТЭЗҮ хийсэн огноо | | 2017 |
| 25. | Ашиглах хугацаа | | 25 жил |
| 26. | Жилийн хүчин чадал | | - |

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Тэсрэх бодисын үйлдвэр нь Бор-Өндөр УБҮ-ээс зүүн урагш 5 км зайд байрлана. Мөн Улаанбаатар хотоос зүүн урагш 310 км, Өндөрхаан хотоос баруун урагш 155 км, Дархан сумаас урагш 55 км, Сайншанд хотоос баруун хойш 146 км, Их хэт сумын төвөөс баруун урагш 45 км, Хар Айрагийн төмөр замын өртөөнөөс зүүн хойд зүгт 45 км, Бор-Өндөрийн уурхайчдын хотхоноос зүүн хойш 1.5 км зайд оршдог. Төслийн талбайн төв нь 1445.7 м үнэмлэхүй өндөртэй, Их Бор-Өндөр овооноос ЗХ-45° азимутаар 3.8 км зайд байрлалтай.




*Зураг 1. Тэсрэх бодисын үйлдвэрийн талбайн байршлын тойм зураг*

Тус тэсрэх бодисын үйлдвэр нь жилд 2600 тн/жил тэсрэх бодис үйлдвэрлэх хүчин чадалтай. Тус үйлдвэр жилийн 4 улиралд ажиллана. Тэсрэх бодисын агуулах нь 60 тн, аммиакийн шүүний агуулах 120 тн багтаамжтай.

Энгийн тэсрэх бодис бэлтгэх зориулалт бүхий сэвсгэржүүлсэн аммиакийн шүүг дизелийн түлш, нунтаг нүүрсний хамт 92:6:2 гэсэн харьцаагаар технологийн дагуу хольж энгийн тэсрэх бодисыг үйлдвэрлэх бөгөөд бортоглон савлах болон уутлан савласан байдлаар бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ. Бүтээгдэхүүний

детонацийн хурд, тэсрэлтийн хүчийг нэмэгдүүлэх зорилгоор нүүрсний нунтаг нэмж хүчитгэсэн энгийн тэсрэх бодис үйлдвэрлэнэ.

Аммиакийн шүүний бункер нь 120 кг багтаамжтай. Энгийн найрлагатай тэсрэх бодисын үндсэн түүхий эдийн нэг дизель түлшний суурин савны багтаамж нь 1000 л бүхий 2 ш байна. Бункерт аммиакийн шүүг механик аргаар жигд өгөх ба шурган холигчийн хажуугаас аммиакийн шүүний урсгалд тохируулан дизель түлшийг шахаж өгнө. Үйлдвэрийн технологийн үйл ажиллагааг хамгийн тохиромжтой, найдвартай, аюулгүй байдлыг баталгаажуулахын тулд тогтмол хяналт тавьж ажиллана. УИ-2 энгийн найрлагатай тэсрэх бодис үйлдвэрлэх төхөөрөмж нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ механик аргаар 38 кг хэмжээтэй савлан бэлтгэнэ.

УИ-2 энгийн найрлагатай тэсрэх бодис үйлдвэрлэх төхөөрөмж бол үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж юм.

Тус төхөөрөмжийг ажиллуулж хүлээн авах бункерт (1) аммиакийн шүү хийхэд диск (2) –ийн хөдөлгөөн шнек (4)-ийн эргэлтээр бункерийн хана, диск хоорондын завсраар аммиакийн шүү холих камерт (3) өгөгдөнө. Дизель түлштэй хэмжигч савнаас түүнийг урсгалаар нь вентилээр дамжуулан холих камер дахь аммиакийн шүүнд өгнө. Вентиль нь төхөөрөмжийг ажиллуулахад хамт онгойно. Дамжуургын хөдөлгүүрийг залгахад диск (2), шнек (4) эргэлтэнд орж аммиакийн шүү нь дамжуулах шнек (5)-ээр түрэгдэн дизелийн түлштэй холигдоно. Аммиакийн шүү, дизель түлштэй бүрэн холигдоход сэлгэлт хийгдэн дамжуулах шнек (5) эсрэг тийш эргэлтэнд орж тэсрэх бодис буулгах люкэнд хүргэгдэнэ. Хатуурсан аммиакийн шүүг хүлээн авах бункерийн ханан дахь товруу (6) дискийн тусламжтайгаар бутлагдана.




*Зураг 2. Энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын бүтэц*

**Усны хэрэглээ**

Лаборатори: Төслийн технологи үйл ажиллагаанд ус ашиглахгүй. Харин тэсрэх бодисын шингээх чадвар, нягт, мөхлөгийн бүтэц, бутрамтгай чанар, чийглэх зэргийг тодорхойлох лабораторит ус хэрэглэх ба лабораторийн ус хэрэглээ БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07-р сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалын 14-р хавсралтын дагуу 1 ажилтан 300 л ус хэрэглэнэ гэж байдаг боловч төслийн ТЭЗҮ-д 50 л/хон гэж тооцсоноор тооцов. Лаборатори 1 ажилтантай ба жилд 237 хоног ажиллах тул 237 x 50 л = 11.85 $м^3$ ус хэрэглэхээр байна.

Унд ахуй: Тус үйлдвэрт 16 хүн ажиллана. Үйлдвэрийн усны хэрэглээг зөөврөөр худгаас хангана. Усны хэрэглээг А/301 тоот тушаалын 12-р хавсралтын дагуу 1 хүн 1 хоногт 20 л ус хэрэглэнэ гэж үзэв. Иймд унд ахуйн ус хэрэглээнд 1 хоногт 0.32 $м^3$, 1 сард 7.04 $м^3$, 1 жилд 84.48 $м^3$ ус хэрэглэнэ.

Төслийн хэрэгцээнд 0.004 л/сек буюу нийт 96.33 $м^3$/жил ус хэрэглэхээр байна.

*Хүснэгт 1. Усны нийт хэрэглээ*

| № | Ус хэрэглээний эх үүсвэр | Ус хэрэглээний хэмжээ, $м^3$ | | |
|---|---|---|---|---|
| | | 1 хоног | 1 сар | 1 жил |
| 1 | Унд ахуй | 0.32 | 7.04 | 84.48 |
| 2 | Лаборатори | 0.05 | 0.98 | 11.85 |
| | Нийт | 0.37 | 8.02 | *96,33* |

# БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Судалгааны талбай нь уур амьсгалын мужлалын хувьд хүйтэн өвөлтэй, хуурай сэрүүвтэр зунтай мужид байрлана. Төслийн талбай нь байгалийн бүсчлэлийн хувьд нийт нутгийн 30-70% нь уулын хөндий, түүний хажуу, нам газар болно. Тус нутаг нь өвөлдөө бага зэргийн цастай хүйтэн, зундаа бороотой, халуун байх ба эх газрын эрс тэс уур амьсгалтай.

Төсөл хэрэгжих талбай орчмын нутаг дэвсгэрийн агаарын жилийн дундаж температур 3.5 – 3.7°С байна. Төсөл хэрэгжих талбай орчмоор жилд унах хур тунадасны хэмжээ 100.9-113.5 мм байдаг. Хэнтий аймгийн хэмжээнд салхины жилийн дундаж хурд нутгийн зүүн өмнөд хэсэгт харьцангуй бага 2.9 м/с, бусад хэсгээр 3.1 – 4.3 м/с байна. Жилийн явцыг авч үзвэл салхины хурдны их утга нь хавар, намрын улиралд ажиглагдаж 4 – 5.7 м/с, бага утга нь өвлийн саруудад ажиглагдаж 2.3 – 4.1 м/с байна.

Ордын геологийн тогтоцод дээд пермийн вулканоген чулуулаг, дээд юра-доод цэрдийн настай вулканоген-тунамал хурдас, триасын боржинлогууд, доод цэрдийн дэл судлын чулуулгууд ба дөрөвдөгчийн хурдасууд орно.

Тус талбай нь геоморфологийн мужлалтаар Монгол Дорнод мужийн Баруун-Уртын дэд мужид хамаарна.

Судалгааны талбай орчмын хамгийн өндөр цэг 1445.7 м өргөгдсөн. Их бор өндөр уул, хамгийн намхан цэг нь 1220 м өргөгдсөн байна. Судалгааны талбай нь ерөнхийдөө долгиорхог хэвгийдүү тал юм.

Тус тэсрэх бодисын үйлдвэрийн талбай нь Бор-Өндөрийн хайлуур жоншны дүүрэгт хамаарах бөгөөд энэ нь Төв Азийн гидрогеологийн гадагш урсгалгүй сав газрын бүрэлдэхүүнд ордог учраас бага хэмжээний агаар мандлын хур тунадасаар тэжээгддэг, тогтмол усны урсгал үгүй, зуны аадар бороотой үед зөвхөн усны урсгалтай хуурай хөндий өргөн хөгжсөн байдаг. Судалгаанд хамрагдсан Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байрлах “Монголросцветмет” ТӨҮГ-ын 0000299698 тоот газар эзэмших гэрчилгээтэй тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн хархүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн Бор-Өндөр-Уулбаяны тойрогт хамааргдана /Монгол улсын үндэсний атлас, 2009/.

Хөрсний ялзмагийн агууламж 1.8-2.6% хооронд хэлбэлзэж өнгөн үедээ 2,67% буюу элэгдэл, эвдрэлд ороогүй зүсэлт 2-н хөрсөн дэхь ялзмагийн агууламжаас илүү байгаа нь хог хаягдлын ялзрал болон бусад төрлийн биологийн бохирдлоос үүдэлтэй юм. Хөрсний гадаргад жижиг хайрга, сайрга, чулуу холилдсон нимгэн хучаастай. Ширхэгийн бүрэлдэхүүнд элсэнцэр хэсэг зонхилох бөгөөд задлан шинжилгээний дүнгээс харахад элсэнцэр механик бүрэлдэхүүн хөрсний бүх үе давхаргуудад зонхилж байна.

Тус үйлдвэрийн талбайн хэмжээ 2.66 га. Эдэлбэр газрын талбайн хэмжээнд хүний үйл ажиллагааны буюу техноген, автоген нөлөөгөөр 0.18 га талбайн хөрс хүчтэй, дунд зэргийн эрчимтэй эвдрэл бий болсон байна.

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байрлах “Монголросцветмет” ТӨҮГ-ын Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Евразийн хээрийн их мужийн Төв Азийн мужийн Алтанширээгийн тойрогт хамаарна. Энэ бүс нутагт хуурай хээрийн бэлчээрийн төрлүүд тархсан ажээ.

Үйлдвэрийн толгодорхог хөндийгээр ургамалжилтын үетэн - алаг өвс бүхий бүлгэмдэл зонхилон тархжээ.

Хөхтөн амьтны бүрэлдэхүүнийг тогтоохын тулд Батсайхан нарын “Монгол орны хөхтөн амьтад” номын баримтлалыг гол болгон тус нутагт тархалт нь тэмдэглэгдсэн зүйлийг төслийн талбайд амьдрах биотоп байгаа эсэхийг ажиглаж харьцуулалт хийв. Үүний дунд 2 зүйл шавж идэштэн, 1 зүйл далавчтан, 2 зүйл туулайтан, 5 зүйл мэрэгчтэн, 6 зүйл мах идэштэн, 1 зүйл туруутан, нийт 6 багийн 17 зүйл амьтан төслийн талбайд тохиолдоно.

Судалгааны талбайд тохиолдох шувуудын хамгаалагдсан байдлыг авч үзвэл Азийн улаан номонд орсон 1 зүйл, Ховор болон ховордсон амьтан, ургамлыг олон улсын хэмжээнд худалдаалах конвенц – CITES-ийн II хавсралтанд орсон 7 зүйл шувуу байна (Хүснэгт 13). Нүүдлийн шувуудыг хамгаалах олон улсын конвенцод элсэн орсон.

Хамгаалагдсан шувуудаас 5 зүйл нь суурин амьдарна. Махчин шувууд цөөрөх үзэгдэл гарч эхлэж байгаа тул олон улсын хэмжээнд тэдгээрийг хамгаалах арга хэмжээ авч эхэлсэн ба тус нутагт амьдрах махчин шувууд (Хүснэгт 10) бүгд CITES, II – Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн II хавсралтад орж хамгаалагдсан. Судалгааны талбай нь тусгай хамгаалаттай газар нутгаас хол зайтай оршдог. Хамгийн ойр орших тусгай хамгаалалттай газар нутаг нь талбайгаас баруун зүгт 47 км зайд орших Чойрын Богд уул, хойно 43 км зайд Дархан уул, түүнээс цааш Хэрлэн Тооно уул байрлана.

# ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах” төслийн ТЭЗҮ болон бусад холбогдох бичиг баримтыг нарийвчлан судалж, төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг БОНХСайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дараах алхамаар тодорхойлсон.

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний орчмыг оруулсан байрзүйн дэвсгэр зураг, агаар, сансрын зургийг бэлтгэж, тэдгээр дээр төсөл хэрэгжүүлэх байршил, түүний үйл ажиллагаа явагдах газар, объектуудыг тэмдэглэв. (Зураг 3).




Зураг 3. Үйлдвэрийн обьект болон хиймэл дагуулын мэдээ

1 - Үйлдвэрийн талбай
2 - Тэсрэх хэрэгсэлийн агуулах
3 - Тэсрэх бодис хадгалах агуулах
4 - Галын хэрэгсэлийн байр
5 - Түүхий эдийн агуулах
6 - Бие засах газар
7 - Галын эсрэг ус хураагуур

Агаарын цохих долгионы зөвшөөрөгдөх зай хэмжээнээс хамааруулан хүн ам, барилга байгууламжийн өртөгдөх зай хэмжээг “Тэсрэх материал хадгалах, тэсэлгээний ажил хийх үеийн аюулгүйн зай тогтоох заавар”-ын дагуу тооцоолоход 900 м зайд сондгой орших байшин барилга, хөдөлгөөн багатай авто болон төмөр зам, агаарын цохилтыг эсэргүүцэх онцгой бат бөх байгууламжид нөлөөлөх зай 900 м, бусад обьектуудад үзүүлэх нөлөөлөл 1750 м байна.

Мөн тоног төхөөрөмж, техникийн дуу шуугиан, хөдөлмөр аюулгүй ажиллагаа алдагдсантай холбоотойгоор хөрс, ургамал, усанд нөлөөлөл үзүүлэх бөгөөд тэсэлгээнээс бусад эдгээр нөлөөллийн бүсийг тодорхойлохдоо БОНХСайдын А-117 тоот аргачлалд заасан нөлөөлөл буурах функцийг ашиглан тооцоолоход нөлөөллийн эх үүсвэрүүдийн тэгш хэмт цэгээс хүчтэй нөлөөлөл 50 м зайд, дунд зэргийн нөлөөлөл 100 м зайд, бага нөлөөлөл 200 м зайд тус тус үүсэхээр байна.

“Эко Хайрхан” ХХК-ийн мэргэжилтэн, экспертүүд хээрийн судалгааны ажлыг нөлөөллийн бүсийн дотор хийж гүйцэтгэв. /Хээрийн судалгааны үр дүнг тус төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлангаас үзнэ үү/.




*Зураг 4. Тэсрэлтийн үеийн нөлөөллийн бүс*




*Зураг 5. Нөлөөлөл буурах функцээр тооцоолсон төслийн нөлөөллийн бүс (Нөлөөллийн эрчим 10 бол хүчтэй, 20 бол дунд, 30 бол бага)*

Төслөөс үзүүлэх сөрөг нөлөөллийг БОНХСайдын А-117 тоот аргачлалд заасан үзүүлэлтээр байгаль орчны шинжилгээ хийж үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 2. Байгаль орчны шинжилгээ*

| № | Байгаль орчны шинжилгээ хийх асуултууд | Тийм | Үгүй |
|---|---|---|---|
| 1 | Газрын гадаргын хэв шинжид гарах өөрчлөлт | + | |
| 2 | Газар ашиглалтын өөрчлөлт | + | |
| 3 | Төсөл хэрэгжүүлэх зориулалтаар усны нөөцийг ашиглах эсэх | + | |
| 4 | Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх эсэх | | + |
| 5 | Үл нөхөн сэргэх болон байгалийн ховор нөөц, баялгийг ашиглах эсэх | | + |
| 6 | Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа явагдах эсэх | + | |
| 7 | Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг үйлдвэрлэх үйл ажиллагаа явагдах эсэх | + | |
| 8 | Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд хатуу хог хаягдал гарах эсэх | + | |
| 9 | Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд шингэн хаягдал /бохир | + | |

| | | | |
|---|---|---|---|
| | ус/ гарах эсэх | | |
| | Орчны бохирдол | | |
| 10 | Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аливаа төрлийн бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгарах эсэх | + | |
| 11 | Дуу шуугианы нөлөө | + | |
| 12 | Чичиргээний нөлөө | + | |
| 13 | Дулааны нөлөө | | + |
| 14 | Цахилгаан соронзон долгионы нөлөө | | + |
| 15 | Цацрагийн нөлөө | | + |
| 16 | Гадаргын болон газрын доорх усанд бохирдуулагч бодис нэвчих үед усны бохирдол үүсэх эсэх | + | |
| | Эрсдэлийн үнэлгээ | | |
| 17 | Хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд үүсэх эрсдэл | + | |
| 18 | Байгаль орчинд үүсэх эрсдэл | + | |
| | Нийгэм-эдийн засаг | | |
| 19 | Төслийн хэрэгжилттэй холбоотойгоор нийгэмд тодорхой өөрчлөлт гарах эсэх | + | |
| 20 | Хүн амын амьжиргааны түвшин өөрчлөгдөх | + | |
| 21 | Бизнесийн таатай орчин бүрэлдэх | + | |
| 22 | Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх | + | |
| 23 | Шинээр ажлын байр бий болох | + | |
| 24 | Орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх | + | |
| 25 | Хөдөлмөр эрхлэлтэд өөрчлөлт гарах | + | |
| 26 | Тухайн орон нутгийн оршин суугчдын зан үйл, шашин шүтлэг зэрэгт сөргөөр нөлөөлөх | | + |
| 27 | Тухайн орон нутгийн оршин суугчдын дасан зохицсон амьдралын хэв маягт сөргөөр нөлөөлөх | | + |
| 28 | Хөгжлийн хэтийн төлөвлөгөө, тухайн үед орон нутагт хэрэгжиж байгаа буюу хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл, бусад хүчин зүйлс байгаа эсэх | | + |
| 29 | Байгаль орчны бохирдол, доройтол үүсгэж болзошгүй зам, тээврийн үйл ажиллагаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд явагдах эсэх | + | |

Дээрх байгаль орчны шинжилгээний үр дүнг үндэслэн байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн эх үүсвэр болон нөлөөлөлд өртөгдөх байгаль орчин, нийгэм эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлохдоо “Магадлан жагсаах арга”-ыг ашиглав. НҮБХХБ болон Байгаль орчин аялал жуулчлалын яамны хамтран хэрэгжүүлж буй Монгол улсын Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд боловсруулсан аргачлалд заасан магадлан жагсаах аргын хувилбарыг нөлөөллийн эх үүсвэр, тэдгээрт өртөгдөх байгаль, нийгэм, эдийн засгийн хам бүрдлийг тодорхойлоход ашигласан болно.

*Хүснэгт 3. Нөлөөллийн магадлан жагсаах аргын матриц*

| **Үзүүлэлт** | Технологийн процесс | | | | | | Нийлбэр |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Химийн бодис, материалыг тээвэрлэх | Химийн бодис ачих, буулгах | Үйлдвэрлэлийн үндсэн процесс | Эцсийн бүтээгдэхүүн, түүний хадгалалт | Аюултай шинжтэй хог хаягдал | Ахуйн хог хаягдал | |
| Агаарын чанар | + | + | + | + | + | + | 6 |
| Хөрсөн бүрхэвч | + | + | 0 | + | + | + | 4 |
| Ургамлан нөмрөг | + | + | 0 | + | + | + | 4 |
| Геологийн тогтоц | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Газрын доорх усны нөөц, горим | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Газрын доорхи усны чанар | 0 | + | 0 | + | + | + | 4 |
| Гадаргын усны нөөц, горим | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Геоморфологийн хэв шинж | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Биологийн олон янз байдал, зүйлийн элбэгшил, тархалт | + | 0 | + | 0 | + | + | 4 |
| Хүн амын амьжиргааны түвшин өөрчлөгдөх | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Тухайн орон нутгийн оршин суугчдын зан үйл, шашин шүтлэг зэрэгт сөргөөр нөлөөлөх | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хүний эрүүл мэнд | + | + | + | + | + | + | 6 |
| Нийлбэр | 5 | 5 | 3 | 5 | 6 | 6 | |

*Жич: (+) – нөлөөлөл үзүүлнэ, (0) нөлөөлөл үзүүлэхгүй, (x) хамааралгүй.*

Магадлан жагсаах аргын үнэлгээний үр дүнгээс үзэхэд төслийн үйл ажиллагаанаас байгаль, нийгэм-эдийн засгийн бүрдэл хэсгийн хамгийн их нөлөөлөлд өртөгдөх бүрдэл хэсэг нь агаарын чанар, хүний эрүүл мэнд байна. Технологийн бүх процесс нь агаарын хими, физик шинж чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, ачих буулгах, хадгалалтын горим алдагдсан үед агаарт тоосжилт үүсэх, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт асгарсан тохиолдолд хөрс, ургамлан чанарыг доройтуулахаас гадна хөрсний нэвчилтээр газрын доорхи усыг бохирдуулж болзошгүй юм. Мөн

тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед үүсэх дуу чимээ нь агаарын физик шинж чанарт нөлөөлнө.

Төсөл хэрэгжүүлэгчийн онцгой анхаарч ажиллах нэг асуудал бол аюултай хог хаягдал юм. Хог хаягдал үүсэхээс, устгах хүртэлх процессод орчны агаарын чанар, усны чанар, хөрсний чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй тул төслийн аливаа үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг “Хог хаягдлын тухай хууль”-ийн дагуу хадгалж, устгах шаардлагатай.

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тус байгаль орчны менежментийн 2022 оны төлөвлөгөөг Монгол улсын Байгаль хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох журам дүрэм, “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах” төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг үндэслэн боловсруулсан.

# БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ

*Хүснэгт 4*

Бор-Өндөр УБҮ-ийн Тэсрэх материалын үйлдвэр, агуулахын, Төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан, Байгаль орчны менежментийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт

| Д/д | Үзүүлэлт | Төлөвлөсөн ажил | Гүйцэтгэл | Зардал /сая.төг/ |
|---|---|---|---|---|
| | | **Агаар** | | |
| 1. | I. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дүн шинжилгээг үндэслэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх | Орчны хяналт шинжилгээг 2 удаа хийж гүйцэтгүүлсэн | Үйл ажиллагааны зардалд |
| | | **Гадаргын ба газрын доорх усны нөөц** | | |
| | | Бор-Өндөр УБҮ-ийн хамт | Бор-Өндөр УБҮ-ийн хамт | |
| | | **Хөрсөн бүрхэвч** | | |
| | | Автозамын /Автогрейдерээр тэгшлэх/ сайжруулалтыг гүйцэтгэх | Автозамыг тогтмол Автогрейдерээр тэгшлэж сайжруулан ажилласан. | Үйл ажиллагааны зардалд |
| | | Олон салаа зам гаргахгүй байх хуурайшилт ихтэй үед замын усалгаа хийх | Тээвэрлэлтийн замыг шаардлагатай үед усалгаа арчилгаа хийж ажилласан. | Үйл ажиллагааны зардалд |
| | | Химийн бодисыг тээвэрлэх, хадгалах, хэрэглэх аюулгүй ажиллагааны дүрэм, журам, стандартыг сахин биелүүлэх | Дүрэм, журам, стандартын дагуу ажилласан. | - |
| | | **Газрын хэвлий** | | |
| | | Бор-Өндөр УБҮ-ийн хамт | Бор-Өндөр УБҮ-ийн хамт | - |
| | | Ургамлан нөмрөг | | |
| | | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дүн шинжилгээг үндэслэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх | Орчны хяналт шинжилгээний дүнг үндэслэн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлж ажилласан | Үйл ажиллагааны зардалд |
| | | Амьтны аймаг | | |
| | | Бор-Өндөр УБҮ-ийн хамт | Бор-Өндөр УБҮ-ийн хамт | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Цацраг | | |
| | | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дүн шинжилгээг үндэслэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх | Орчны хяналт шинжилгээг 2 удаа хийж гүйцэтгүүлсэн | |
| 2. | II. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | Техникийн нөхөн сэргээлт | | |
| | | Төлөвлөөгүй. | - | - |
| | | Биологийн нөхөн сэргээлт | | |
| | | Төлөвлөөгүй. | | |
| | | Хаалтад бэлтгэх | | |
| | | Төлөвлөөгүй. | | |
| 3. | III. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу тэсрэх бодисын үйлдвэрт дүйцүүлэн хамгааллын үйл ажиллагаа хэрэгжихгүй. | - | - |
| 4. | IV. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | Тус тэсрэх бодисын үйлдвэрийн нөлөөллийн бүсэд суурьшлын бүс байхгүй, малчин өрх байхгүй. | - | - |
| 5. | V. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | Археологийн дурсгал, Палентологийн дурсгал | | |
| | | Түүх, соёлын өвийн дурсгалт зүйл илрээгүй байгаа болно. | | - |
| 6. | VI. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | Аммоний нитрат | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Амьсгалах тохиолдолд:<br>Цэвэр агаарт гарна. Хэрэв амьсгалахгүй бол хиймэл амьсгал хийнэ. Амьсгалахад хүнд байгаа тохиолдолд хүчилтөрөгчөөр амьсгалуулна. Эмнэлгийн тусламж яаралтай үзүүлэх хэрэгтэй.<br>Залгих тохиолдолд:<br>Хэрэв залгисан бол Албадан бөөлжүүлж болохгүй. Их хэмжээгээр ус уулгана. Эмнэлгийн тусламж яаралтай үзүүлэх хэрэгтэй. Ухаан алдсан хүнд амаар нь юм өгч хэрхэвч болохгүй.<br>Арьсанд хүрэлцэх үед:<br>Бохирдсон хувцас ба гутлыг тайлсны дараа 15 минутаас доошгүй хугацаагаар арьсны бохирдсон хэсгийг их хэмжээний усаар угаана.<br>Нүдэнд үйлчлэх үед:<br>Нүдний дээд ба доод зовхийг нээж 30 минутаас доошгүй хугацаагаар их хэмжээний усаар шавшиж угаана.<br>Эмнэлгийн мэргэжлийн эмчийн тусламж яаралтай үзүүлэх. | Аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн зааварчилгаа өгч ажилласан. Үйлдвэрлэл явагдахгүй байгаа.<br><br>Тээвэрлэлт хадгалалт хийхдээ ажилтан бүрт хамгаалах хэрэгсэл, аюулгүй ажиллагааны заадарчилгаа өгж ажилласан. | Үйл ажиллагааны зардалд |
| | | Дизель түлш | | |
| | | Амьсгалах тохиолдолд:<br>Цэвэр агаарт гаргана. Хэрэв амьсгал хэвийн биш эсвэл амьсгалын замын саатална орсон бол хиймэл амьсгал хийх, эсвэл хүчилтөрөгчөөр амьсгалуулна. Эмнэлгийн тусламж яаралтай дуудна.<br>Залгих тохиолдолд:<br>Залгисан тохиолдолд эмчийн зааврын дагуу албадан бөөлжүүлэх хэрэгтэй. Ухаан алдсан хүнд амаар нь юм өгч хэрхэвч болохгүй. Эмнэлгийн тусламж яаралтай үзүүлэх.<br>Арьсанд хүрэлцэх үед:<br>Хүрэлцсэн хэсгийг савантай усаар 15 минутаас доошгүй хугацаагаар угаах хэрэгтэй. Бохирдсон хувцас ба гутлыг солино. Хэрэв цочрол | Аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн зааварчилгаа өгч ажилласан. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | намжихгүй бол эмнэлгийн тусламж яаралтай үзүүлэх хэрэгтэй.<br>Нүдэнд үйлчлэх үед:<br>Нүдний дээд ба доод зовхийг нээж 30 минутаас доошгүй хугацаагаар их хэмжээний усаар шавшиж угаана. Эмнэлгийн тусламж яаралтай үзүүлэх хэрэгтэй. | | |
| | | Химийн бодисын осол эрсдэлээс сэргийлэх | | |
| | | Химийн хорт болон аюултай бодисыг зориулалтын агуулахад, хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгалах, химийн бодисын хадгалалт, ашиглалт, зарцуулалтыг тогтмол хянах. | Зориулалтын дагуу хадгалж тогтмол хяналт бүртгэл хөтөлж ажилладаг | |
| | | Химийн бодисыг тээвэрлэх, хадгалах, хэрэглэх аюулгүй ажиллагааны дүрэм, журам, стандартыг сахин биелүүлэх. | Аюулгүй ажиллагааны дүрэм, журам, стандартын дагуу ажилласан | |
| | | Дизель алдагдах нөхцөлд цуглуулах сан байгуулахэ | Дизель түлш цуглуулах савтай, дизель түлшийг одоогоор ашиглахгүй зориулалтын зуурагч машинд боловсруулж байна. | |
| | | Галын аюулаас сэргийлэх | | |
| | | Цахилгаан тоног хэрэгслийн газардуулга бүрэн бүтэн байх. | Цахилгаан тоног төхөөрөмжийн газардуулгатай. | |
| | | Үйлдвэрийн технологи хэрэглээ, унд ахуйн, галаас хамгаалах усны нэгдмэл шугамаар тоноглогдсон байх. | Үйлдвэрийн технологи болон галаас хамгаалах усны нэгдмэл шугамаар тоноглогдсон. | |
| | | Болзошгүй гал түймрийн үед ашиглах техник хэрэгсэл, багаж төхөөрөмжтэй байх, | Бор-Өндөр УБҮ нь Аврах алба тай бөгөөд бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдсан, тухайн байгууламж тус бүр дээр гал унтраах бүрэн хэрэгсэлтэй болно. | |
| 7. | VII. Хог, хаягдлын менежментийн | Ахуйн | | |
| | | Үйлдвэрийн ахуйн хатуу хог хаягдалд хоол хүнс, түлш, угаалга цэвэрлэгээний материалын сав, | Хог хаягдал ангилан ялгах сав байрлуулсан. Ашиглах боломжгүйг | Үйл ажиллагааны |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө | баглаа боодол болох мод, цаасан хайрцаг, хуванцар болон шил сав,гялгар уут зэрэг матеиалуудыг цуглуулаад хуванцар, шил, төмөр ба бусад төрлөөл нь хуваан ангилж, цааш ашиглах боломжгүй хог хаягдлыг зөвшөөрөлтэй ААН-ээр зайлуулуулах, | тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжид шилжүүлсэн. | зардалд |
| | | Ахуйн хог хаягдлыг зориулалтын саванд түр хадгалах, | Ахуйн хог хаягдлыг зориулалтын саванд түр хадгалж тусгай зөвшөөрөл бүхий “Бор-Өндөр Хот тохижилт” ТБАГУТҮГ-тай гэрээ байгуулан ачиж сумын төвлөрсөн цэгт төвлөрүүлдэг. /Гэрээг хавсаргав/ | |
| | | Халдваргүйжүүлэх, нян устгах ариутгалыг орон нутгийн мэргэжлийн байгууллагаар хийлгэх, | Халдваргүйжүүлэх, нян устгах ариутгалыг Бор-Өндөр УБҮ-ийн ХАБЭА-н хэлтэс болон мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн. | |
| | | Үйлдвэрийн | | |
| | | Химийн бодисын сав баглаа, боодол, үлдэгдлийг Ахуйн шинжтэй хог хаягдлаас тусад нь ангилан түр хадгалах хэрэгтэй. | Аюултай хог хаягдал түр хадгалах байгууламжид ангилан ялгаж хадгалаад тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж “Түмэн эгшиг ХХК”-д шилжүүлсэн. /Гэрээг хавсаргав./ | Үйл ажиллагааны зардалд |
| | | Хог хаягдлыг ангилан ялгах бункер байрлуулах | Тэсрэх материал боловсруулах үйл ажиллагаа явагдахгүй байгаа учир хог хаягдал гарахгүй, хог хаягдал түр байршуулах хэсэгтэй. | - |
| | | Аюултай | | |
| | | Аюултай хог хаягдал тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагаа эрхэлдэг эрх бүхий нэгж байгууллагатай гэрээ байгуулан нийлүүлэх, | Тусгай зөвшөөрөл бүхий “Түмэн эгшиг” ХХК, “Эко минериал” ХХК, “Хай би ойл” ХХК-д шилжүүлсэн. / Гэрээг хавсаргав/ | Үйл ажиллагааны зардалд |
| 8. | VIII. БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага | Автозамын /Автогрейдерээр тэгшлэх/ сайжруулалтыг гүйцэтгэн ажиллах, | Автозамыг Автогрейдерээр тогтмол тэгшлэж сайжруулалт хийн ажилласан. | Үйл ажиллагааны зардалд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | зохион байгуулалтын төлөвлөгөө | Үйлдвэр болон агуулахад химийн бодистой ажилчид хүрэлцсэн үед гар угаах угаалтуур бий болгох, | Гар угаах цэвэрлэх хэсэгтэй | |
| | | Нөхөн сэргээлт төлөвлөхгүй<br>Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу тэсрэх бодисын үйлдвэрт дүйцүүлэн хамгааллын үйл ажиллагаа хэрэгжихгүй | - | |
| | | Тус тэсрэх бодисын үйлдвэрийн нөлөөллийн бүсэд суурьшлын бүс байхгүй, малчин өрх байхгүй. | - | |
| | | Түүх, соёлын өвийн дурсгалт зүйл илрээгүй байгаа болно. | - | |
| | | Химийн хорт болон аюултай бодисыг зориулалтын агуулахад, хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгалах, химийн бодисын хадгалалт, ашиглалт, зарцуулалтад тогтмол хяналт тавих. | Химийн хорт болон аюултай бодисыг зориулалтын агуулахад, хадгалах нөхцлийн дагуу хадгалж, ашиглалт зарцуулалтад хяналт тавьж бүртгэлжүүлэн ажилласан. | |
| 9. | IX. БОМТ-ний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг /2022 оны/ 10 сард IV улиралд олон нийтэд тайлагнах | Төлөвлөгөөний дагуу олон нийтийн цахим сүлжээнд тайлагнаж ажилласан. | Үйл ажиллагааны зардалд |
| 10 | X. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | Орчны хяналт шинжилгээг тухайн жилд 2 удаа гүйцэтгүүлэх | Орчны хяналт шинжилгээг тухайн жилд 2 удаа гүйцэтгүүлсэн. /Гэрээ, холбогдох материалыг хавсаргав./ | Үйл ажиллагааны зардалд |

# ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсч болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тодорхой тусгана” хэмээн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2.7-д заасан байна. Үүний дагуу бид байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулсан.

***Зураг 6. Дээж авах цэгийн байршил***



*Хүснэгт 5. Мониторингийн цэгийн координат*

| № | Хяналт шинжилгээний төрөл | Өргөрөг | Уртраг |
|---|---|---|---|
| 1 | Хөрсний химифизик шинж чанарын үзүүлэлт | 46° 14' 38.93" N | 109° 27' 32.832" E |
| | | 46° 14' 39.01" N | 109° 27' 35.080" E |
| | | 46° 14' 40.44" N | 109° 27' 25.109" E |
| 2 | Хөрсний бактерологийн үзүүлэлт | 46° 14' 38.93" N | 109° 27' 32.832" E |
| 3 | Хөрсний бохирдлын үзүүлэлт | 46° 14' 38.93" N | 109° 27' 32.832" E |
| | | 46° 14' 39.01" N | 109° 27' 35.080" E |
| | | 46° 14' 40.44" N | 109° 27' 25.109" E |
| 5 | Агаарын чанар, хөдөлмөр аюулгүй ажиллагаа | 46° 14' 38.93" N | 109° 27' 32.832" E |
| | | 46° 14' 39.01" N | 109° 27' 35.080" E |
| | | 46° 14' 40.44" N | 109° 27' 25.109" E |
| 6 | Цацраг | 46° 14' 39.01" N | 109° 27' 32.080" E |

# ДҮГНЭЛТ

“Монголросцветмет” ТӨҮГ-ын харъяа Бор-Өндөр УБҮ нь Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах” төслийг хэрэгжүүлж байна.

Бор-Өндөр УБҮ нь Тэсрэх бодисын үйлдвэр дээр боловсруулалтын үйл ажиллагаа явуулахгүй байгаа бөгөөд зориулалтын боловсруулагч машинаар гүйцэтгэж байна

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тус төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хяналт шинжилгээ хийх зорилго бүхий нийт 10 төрлийн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт төсөв 3,0 сая.төг зарцуулсан.

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
# ТОГТООЛ

2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар 103 | Улаанбаат хот

"Монголросцветмет" хязгаарлагдмал хариуцлагатай компанийг төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэс Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэс Монгол Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолын 2 дахь хэсгийг тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монголросцветмет" хязгаарлагдмал хариуцлагатай компанийг төр өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулсугай.

2. "Монголросцветмет" төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг хавсра ёсоор баталсугай.

3. "Монголросцветмет" төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг улс бүртгэлд бүртгүүлэх, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаа тогтоох мөрдүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбо даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд — У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга — Л.ОЮУН-ЭРДЭНЭ

БАТЛАВ:
"БОР-ӨНДӨР" УБҮ-ИЙН
ЗАХИРАЛ

Б.МАГСАРЖАВ

БАТЛАВ:
"БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ"
ОНТҮГ-ЫН ДАРГА

М.БАЗАРДАРЬ

"БОР ӨНДӨР" УУЛЫН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БОЛОН
"БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ" ТБАГУТҮГ -ТАЙ
"ХОГ ХАЯГДАЛ АЧИЖ ТЭЭВЭРЛЭХ ТУХАЙ" ГЭРЭЭ

№ 84-2022-04-05

2022 оны 02 сарын 01-ний өдөр Бор-Өндөр сум

## НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Гэрээний зорилго нь Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт Ашигт малтмал ашиглаж олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахдаа, тус сумын хөгжилд тодорхой дэвшил үзүүлж, орон нутгийн нийгэм, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэн, ажлын байрны болон орчны бохирдол, хог хаягдлыг хууль журамд нийцүүлэн зайлуулах, хамтран ажиллахад оршино.

1.2 Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль орчны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд мөрдөгдөнө.

1.3 Нэг талаас "БОР-ӨНДӨР" УБҮ /цаашид УБҮ гэх/-ийг төлөөлж Аюултай болон энгийн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн Г.Одонтунгалаг, нөгөө талаас "БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ" ТБАГУТҮГ-ыг төлөөлж, мастер Ө.Нямжав /цаашид ТБАГУТҮГ гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг доорхи нөхцлөөр байгуулав.

## ХОЁР: "БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ" ОНТҮГ-ЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

2.1 "Бор-Өндөр Хот тохижилт" ТБАГУТҮГ-ын шаардагдах үйлчилгээ, дэмжлэгийг хууль тогтоомжид нийцүүлэн, гэрээнд заасны дагуу үзүүлнэ.

2.2 УБҮ-ийн ойр орчим, эзэмшлийн талбайг бохирдолгүй байлгах, хог хаягдлыг зориулалтын ангилан ялгах савыг цех хэсгүүдэд байршуулах, тогтсон хуваарийн дагуу хог хаягдал ачиж зайлуулахад шаардагдах нөхцлийг бүрдүүлэх, хангахыг шаардах эрхтэй.

2.3 Хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд шаардлага тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах.

2.4 Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн" аяны хүрээнд УБҮ-ийн хүлэмжийн аж ахуйн мод суулгацын үрсэлгээг тарьж ургуулахад

шаардлагатай ус, ундааны хаягдал хуванцар савыг УБҮ-т нийлүүлж, дэмжлэг үзүүлэх.

ГУРАВ: УБҮ-ИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1 УБҮ-ийн ойр орчим, эзэмшлийн талбайг бохирдолгүй байлгах, оффисын өрөө, цех хэсгүүдийн дотор болон гадна талбайд ангилан ялгах хогийн сав /4 ангилан ялгах/ байршуулах, тогтсон хуваарийн дагуу хог хаягдал ачиж зайлуулахад шаардлагатай нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй.

3.2 Хог хаягдлын тухай хууль, холбогдох журмын дагуу төлбөр, хураамжийг цаг хугацаанд нь төлөх.

3.3 Хог хаягдлын төлбөрийг, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 08 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт /Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамж/-д заасан төлбөрийн дагуу 1 сард 223’000 /хоёр зуун хорин гурван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100182700947 тоот дансанд сар бүрийн 20-ны өдрийн дотор шилжүүлнэ.

ДӨРӨВ: ГЭРЭЭНИЙ ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА, ЦУЦЛАХ

4.1 Энэхүү гэрээ нь 2022 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

4.2 Талууд гэрээг дүгнэж, харилцан тохиролцсоны үндсэн дээр дахин сунгах саналаа 1 сарын өмнө албан бичгээр харилцан мэдэгдэнэ.

4.3 Талууд гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, хариуцлага хүлээгээгүй тохиолдолд аль нэг талын санаачлагаар гэрээг цуцалж болно. Гэрээг цуцлах саналаа нөгөө талд 1 сарын өмнө албан бичгээр ирүүлсэн байна.

ТАВ: ГЭРЭЭГ ДҮГНЭХ

5.1 Энэхүү гэрээний биелэлтийг, гэрээний үйлчлэх хугацаа дуусахаас өмнө буюу ажлын 10 хоногт багтаан 2 тал хамтран дүгнэнэ.

5.2 Гэрээний биелэлтийг хангалттай, хангалтгүй гэсэн үзүүлэлтээр дүгнэнэ.

5.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлснээс үүдэн нөгөө талд ямар нэгэн хохирол учирсан бол буруутай тал нь нөгөө талын хохирлыг барагдуулах үүрэгтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| “БОР-ӨНДӨР” УБҮ-ИЙН АЮУЛТАЙ БОЛОН ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ ХАРИУЦСАН | “БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ” ТБАГУТҮГ -ЫН МАСТЕР МЭРГЭЖИЛТЭН |
| Г.ОДОНТУНГАЛАГ | Ө.НЯМЖАВ |
| Утас: 88745667 | Утас: 99760693 |

ТАНИЛЦСАН:

| | |
|---|---|
| ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР | П.МАШБАТ |
| ЗХ-ИЙН ДАРГА | Ж.ЦОГТБААТАР |
| ТЭЗСХ-ИЙН ДАРГА | Б.ГЭРЭЛТУЯА |
| ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ | Б.МӨНХБАЯР |

ХЯНАСАН:

| | |
|---|---|
| ХУУЛИЙН ЗӨВЛӨХ | Л.ЭНХБААТАР |

2022 оны 02 сарын 01-ны өдрийн
БЧ-2022-01-05 тоот гэрээний хавсралт

## УБҮ-ИЙН ХОГ ХАЯГДАЛ АЧИЖ ТЭЭВЭРЛЭХ ХУВААРЬ

| Д/д | Цех, хэлтэс | Долоо хоног тутмын | | |
|---|---|---|---|---|
| | | Даваа гариг 10.00-11.00 | Лхагва гариг 10.00-11.00 | Баасан гариг 15.00-16.00 |
| 1 | Захиргаа, Уулын цех | + | + | + |
| 2 | Баяжуулах фабрик | + | + | + |
| 3 | Засвар механикийн төв цех | + | + | + |
| 4 | Автотээврийн цех | + | + | + |
| 5 | Дулааны станц | + | + | + |
| 6 | Төмөр замын цех | + | + | + |
| 7 | Материал техник хангамжийн хэлтэс | + | + | + |
| 8 | Эрчим хүчний цех, Аврах алба, Цэвэр усны станц | + | + | + |
| 9 | Баргилт /Пүрэв гариг сард 2 удаа авч байна/ | | + | |

Хуваарь гаргасан:
Аюултай болон Энгийн хог хаягдал
хариуцсан мэргэжилтэн Г.Одонтунгалаг

БАТЛАВ:
БОР-ӨНДӨР УБҮ-ИЙН
ЗАХИРАЛ

Б.МАГСАРЖАВ

“..........”...........” 2022 он

БАТЛАВ:
“БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ”
ТБАГУТҮГ-ЫН ДАРГА

М.БАЗАРДАРЬ

“..........”..........” 2022 он

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ

“ХОГ ХАЯГДАЛ АЧИЖ ТЭЭВЭРЛЭХ ТУХАЙ”

Нэг талаас “Монголросцветмет” ТӨҮГ-ын харъяа ”Бор-Өндөр УБҮ-ийн Аюултай болон Энгийн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн Г.Одонтунгалаг, нөгөө талаас “БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ” ТБАГУТҮГ-ын мастер Ө.Нямжав нар “Бор-Өндөр” УБҮ болон “БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ” ТБАГУТҮГ-ын хооронд байгуулсан 2020 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн BU-2020-02-10 дугаартай “Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ”-ний дагуу 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр энэхүү актыг үйлдэв.

**Дүгнэсэн нь:**

1. “БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ” ТБАГУТҮГ нь энэхүү гэрээний 2.1-2.4, дэх заалтыг бүрэн биелүүлж ажилласан.

2. “Бор-Өндөр” Уулын баяжуулах үйлдвэр нь энэхүү гэрээний 3.1-3.4 дэх заалтыг бүрэн биелүүлж ажилласан.

**Шийдвэрлэсэн нь:**

Гэрээнд заагдсан үүргийг “БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ” ТБАГУТҮГ нь 100%, “Бор-Өндөр” Уулын баяжуулах үйлдвэр нь 100%-ийн биелэлттэй гүйцэтгэсэн байна гэж үзэв.

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

БОР-ӨНДӨР УБҮ-ИЙН
АБЭХХХМ
................ Г.ОДОНТУНГАЛАГ

“ХОТ ТОХИЖИЛТ” ТБАГУТҮГ-ын
МАСТЕР
Ө.НЯМЖАВ

“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ш.АМАР-ОТГОН

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН
ХАРЪЯА БОР-ӨНДӨР УБҮ-ИЙН
ЗАХИРАЛ
2022.05.16
Б.МАГСАРЖАВ

**ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС, ХАЯГДАЛ ХООСОН ПООШИГ**
**БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2022 оны 04-р сарын 19-ны өдөр №БИ-2022-04-04 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 2615134 тоот регистрийн, 90100011063 тоот улсын бүртгэлийн дугаартай **“Хай Би Ойл” ХК-** г төлөөлж менежер Л.Даваагэрэл, нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 2550466 тоот регистр, 9019029071 тоот улсын бүртгэлийн дугаартай, “Монголросцветмет” ТӨҮГ-ын харъяа Бор-Өндөр УБҮ-ийг /цаашид Бор-Өндөр УБҮ гэх/ төлөөлж Аюултай болон энгийн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн Г.Одонтунгалаг нар дор дурдсан зүйлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын Иргэний **/243-261, 476-480-р/** хууль, Хог хаягдлын тухай хуулийн **/Тавдугаар бүлэг, 21-24-р/** холбогдох зүйл заалтыг баримтлан энэхүү техникийн ажилласан тос бэлтгэн нийлүүлэх гэрээг байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ,

1.1 Энэхүү гэрээгээр “Хай Би Ойл” ХК болон Бор-Өндөр УБҮ нь гэрээнд заасан хугацаанд машин механизмын, тоног төхөөрөмжийн, хөдөлгүүрийн, гидрийн болон моторын тосыг солих үед гарах техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдал /цаашид ”АХХ” гэх/-г цуглуулах, тээвэрлэх, бэлтгэн нийлүүлэх болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү гэрээ нь талуудын хооронд хийгдсэн тохиролцоонуудыг агуулж байгаа бөгөөд энэхүү гэрээнд тодорхой байдлаар тусгаж оруулсан заалтуудыг оролцуулахгүйгээр үйлчилгээтэй холбоотой хэлцэл, мэдэгдэл, аман болон бичгээр хийсэн тохиролцоог энэхүү гэрээ орлож байгаа болно.

1.3 Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, хоёр тал гарын үсэг зураагүй бол тэдгээрийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Энэхүү гэрээ нь “Хай Би Ойл” ХК болон Бор-Өндөр УБҮ-ийн төлөөллүүд гарын үсэг зурснаар 2023 оны 04 сарын 19-ний өдөр хүртэл нэг жилийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

2.2 Гэрээнд оролцогч талууд Монгол Улсын Иргэний хуульд зааснаар гэрээний үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлээгүй гэж үзсэн тохиолдолд гэрээг дуусгавар болгохыг санал болгох эрхтэй.

2.3 Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээг үргэлжлүүлэх эсэх талаар харилцан мэдэгдэл ирүүлж сунгана.

2.4 Энэхүү гэрээний нөхцөл, болзол, заалтаас татгалзан дуусгавар болгох тухай санал, шалтгааныг талууд зөвхөн албан бичгээр тайлбарлан гаргана.

## ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Талууд бие биенээсээ энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, хэрэгжүүлэхийг шаардах бүрэн эрхтэй.

3.2 Талууд аюултай хог хаягдал /цаашид АХХ гэх/-г юүлэх, зөөх, тээвэрлэх, машинд ачиж буулгах зэрэг АХХ-г хөдөлгөх тухай бүрт хариуцлагатай байж, ажлын болон агуулахын талбай, газар шороо, байгаль орчинг бохирдуулахгүй байхад шаардлагатай арга хэмжээг авч хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

3.3 АХХ буюу техникийн хаягдал тосыг Бор-Өндөр УБҮ нь ямар нэг биет хог /эрэг, боолт, төмөр, чулуу, хуванцар, даавуу, гялгар уут гэх мэт/, механик хольц болон хөргөлтийн шингэн /тосол/, хурдны хайрцагны тос /АКТ/-ны хольцгүйгээр аль болох нэг төрлөөр цуглуулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.

3.4 “Хай Би Ойл” ХК нь Бор-Өндөр УБҮ-ийн цуглуулан ангилж буй АХХ буюу техникийн хаягдал тосны чанарын асуудлаар бэлтгэн нийлүүлэгч талд бичгээр шаардлага хүргүүлэх эрхтэй.

3.5 Энэхүү гэрээний дагуу өгөх шаардлагатай эсхүл өгөхийг зөвшөөрсөн аливаа мэдэгдлийг бичгээр үйлдэх бөгөөд түүнийг биечлэн хүргүүлэх эсхүл доор заасан цахим шуудангийн хаягаар илгээсэн тохиолдолд аливаа мэдэгдлийг хүлээж авснаа талууд бичгээр хариу мэдэгдэж санхүүгийн анхан шатны баримт үйлдэн баталгаажуулах үүрэгтэй.

3.6 “Хай Би Ойл” ХК бэлтгэн нийлүүлэгчээс тээвэрлэгдэн ирсэн энэхүү гэрээний 3.3 дахь заалтын дагуу АХХ-ыг тохирох эсэхийг өөрийн лабораторт судалж, шинжилсний үндсэн дээр хорогдол тооцон авах эрхтэй.

3.7 Энэхүү гэрээ байгуулсантай холбогдон олж авсан талуудтай холбоотой мэдээлэл, баримтын нууцлалыг гэрээ байгуулснаас хойш хоёр тал хугацаагүйгээр чанд хадгалах бөгөөд аль нэг тал нөгөө талд зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжийн дагуу шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх, гэрээнд заагдаагүй зорилгоор ашиглахгүй байх үүрэгтэй.

3.8 Бор-Өндөр УБҮ-ийн нийлүүлсэн техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдлыг хүлээн авснаар бүх эрсдэл, хариуцлага “Хай Би Ойл” ХК-д шилжинэ. Хүлээн авсан аюултай хог хаягдлал болон хаягдал хоосон поошигийг “Хай Би Ойл” ХК нь хэрхэн ашиглах, ашигласан нь Бор-Өндөр УБҮ-т үл хамаарна.

## ДӨРӨВ. БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ

4.1 Бор-Өндөр УБҮ нь бэлтгэн нийлүүлж буй шаардлагыг хангасан техникийн хаягдал тос (АХХ)-ын Хаягдал хоосон поошигийг ямар нэгэн төлбөрийн нөхцөлгүйгээр “Хай Би Ойл”ХК-д нийлүүлнэ. Бэлтгэн нийлүүлсэн АХХ-ын хэмжээг талуудын хүлээлгэн өгсөн болон хүлээн авсан ажилтны гарын үсгээр баталгаажсан санхүүгийн анхан шатны баримтын бичилтийг үндэслэн тогтооно.

4\. Бор-Өндөр УБҮ-ийн бэлтгэн нийлүүлсэн АХХ-н хэмжээгээр улиралд тооцоо нийлж, “Хай Би Ойл” ХК нь Байгаль Орчны Яаманд мэдээлдэг мэдээ тайландаа тусгаж тайлагнана.

## ТАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

5.1 Ямар ч тохиолдолд аль нэг тал түүний хяналтаас гарсан аливаа шалтгаан, нөхцөл байдлын улмаас шууд эсхүл шууд бус байдлаар, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй, үүргийн биелэлт нь хойшлогдсон тохиолдолд нөгөө талын өмнө хариуцлага хүлээхгүй.

5.2 Тийм шалтгаан, нөхцөл байдалд: гал түймэр, үер, ажил хаялт, үймээн, хорлон сүйтгэх ажиллагаа, дэлбэрэлт, цаг уурын сөрөг нөхцөл, зайлсхийх боломжгүй золгүй явдал, ажиллах хүч, материал, тээвэр эсхүл үйлчилгээ олдохгүй байх, давагдашгүй хүчин зүйлс эсхүл дайсагнагч улсын үйл ажиллагаа, нөгөө талын үйлдэл, шүүхийн шийдвэр, тушаал,

хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй, үүргийн биелэлт нь хойшлогдсон тохиолдолд нөгөө талын өмнө хариуцлага хүлээхгүй.

5.2 Тийм шалтгаан, нөхцөл байдалд: гал түймэр, үер, ажил хаялт, үймээн, хорлон сүтгэх ажиллагаа, дэлбэрэлт, цаг уурын сөрөг нөхцөл, зайлсхийх боломжгүй золгүй явдал, ажиллах хүч, материал, тээвэр эсхүл үйлчилгээ олдохгүй байх, давагдашгүй хүчин зүйлс эсхүл дайсагнагч улсын үйл ажиллагаа, нөгөө талын үйлдэл, шүүхийн шийдвэр, тушаал, тогтоол эсхүл Засгийн газрын эрх бүхий байгууллагын журам эсхүл зөвшөөрлийг алдах явдал бөгөөд энэ бүхэн аль ч талын үйлдэлд үндэслэгдээгүй байх ёстой.

5.3 Дээрхээс шалтгаалах ажил зогсоолт эсхүл энэ гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээний гүйцэтгэл тасалдсаны улмаас цаг хугацааны хувьд хойшлогдох асуудлыг аль болох яаралтай засаж залруулна.

## ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

6.2 Энэхүү гэрээнд заасан хэлцэлүүд хэрэгжсэн эсэхийг үл харгалзан гэрээнд тусгагдсан болон гэрээг бэлтгэх, хэрэгжүүлэх үед гэрээнд оролцогч талуудын зүгээс гарсан аливаа зардлыг талууд өөр өөрсдөө хариуцна.

## ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

7.1 Талууд харилцагч талынхаа бизнесийн нэр хүндийг хүндэтгэж, тэгш эрхийн зарчимд тулгуурлан ажиллана.

7.2 Талууд гэрээний хугацаанд харилцан ашигтай, найрсаг байдлаар хамтран ажиллаж аливаа маргааныг зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд хэрэв тодорхой зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу харъяалагдах шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

| ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ: | НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ: |
| --- | --- |
| “Хай Би Ойл” ХК-ийн | Бор-Өндөр УБҮ-ийн Аюултай болон энгийн хог |
| менежер Л.Даваагэрэл | хаягдал хариуцсан мэргэжилтэн Г.Одонтунгалаг |
| /гарын үсэг/ | /гарын үсэг/ |

## ТАЛУУДЫН АЛ

| | |
| --- | --- |
| Монгол улс, Улаанбаатар хот,<br>Сонгинохайрхан дүүрэг , 20-р хороо,<br>Сонсголонгийн /18135/. 110.<br>Утас: 8811-9740, 99904034,80010277 | Хэнтий аймаг, Бор-Өндөр сум,<br>1-р баг, Үйлдвэр1 гудамж<br>Бор-Өндөр УБҮ-ийн байр<br>Утас: 80898194, 88745667<br>Цахим шуудан: mrtsm.borundur@gmail.com |

БАТЛАВ.
“ЭКОМИНЕРАЛ ТРЕЙД” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ЭКОМИНЕРАЛ ТРЕЙД ХХК

.............................. П.БЯМБАДОРЖ

БАТЛАВ.
“БОР-ӨНДӨР” УБҮ-ИЙН
ЗАХИРАЛ

...................................Б.МАГСАРЖАВ

# АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 02 сарын 20-ний өдөр №Ш-22/ 84-2022-04-02 Улаанбаатар хот

Нэг талаас **“Экоминерал трейд” ХХК** /цаашид “Хүлээн авагч” гэх/ төлөөлж менежер албан тушаалтай О.Батхишиг, Нөгөө талаас **“Монголросцветмет” ТӨҮГ**-ын харьяа Бор-өндөр УБҮ /цаашид “Үүсгэгч” гэх/ төлөөлж Аюултай болон энгийн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн Г.Одонтунгалаг нар харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хуулийн 10.2.5 дахь заалт, Засгийн газрын ***2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал*** болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

## НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
1.2. Эл гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртгэл дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

## ХОЁР. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээтэй байна.
2.2. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртгэл үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
2.3. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ ***БОАЖЯСайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг*** бүрдүүлж өгнө.
2.4. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлж хүлээн авагчид шилжүүлнэ.

## ГУРАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР

3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2022 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2023 оны 02 сарын 20 өдрийг хүртэл 1 /нэг/ жилийн хугацаатай байна.
3.2. Эхний нийлүүлэлт нь гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор үүсгэгч нь хүлээн авагчид шилжүүлсэн байна.
3.3. Энэхүү гэрээний хавсралт №1-д заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдалын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн

хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.

3.4. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр 10-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч тал үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хүлээн авагчийн байранд аюултай хог хаягдал хүргэх хугацааг товлоно.

3.5. Хүлээн авагч нь үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цаг аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

3.6. Үүсгэгчийн шилжүүлэх аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах бүх зардлыг хүлээн авагч тал хариуцна.

## ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

*4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:*

4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.

4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.4-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүлээлгэн өгнө.

4.1.3 Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, тээвэрлэгчид 1 хувь, хүлээн авагчид 2 хувийг илгээж, хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.

4.1.4 Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.

4.1.5 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлснээс бусдын эрүүл мэнд, амь нас, талуудын эд хөрөнгө болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч тал хариуцна.

4.1.6 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа хүлээн авагчид шилжүүлэх тухайгаа 10-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид мэдэгдэнэ.

*4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг*

4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.4-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах эрхтэй.

4.2.2 Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь гэрээний 2.4-д заасан шаардлагыг хангаагүй, дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.

4.2.3 Үүсгэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр аюултай хог, хаягдлыг гэрээнд заасан буюу товлосон хугацаанаас 30-аас дээш хоногоор хүлээн авагчид шилжүүлэлгүй хоцроовол хүлээн авагч тал гэрээг нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.

4.2.4 Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.

4.2.5 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.

4.2.6 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авснаас хойших түүний хадгалалт, дахин боловсруулалтыг хариуцна.

4.2.7 Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

## ТАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ, ШИЛЖҮҮЛЭН АВАХ

5.1. Үүсгэгч гэрээгээр тохиролцсон хугацаандаа аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу хаягдлыг УБ, Налайх дүүрэг, 3-р хороо нутаг дэвсгэрт орших “ЭКОМИНЕРАЛ ТРЕЙД ХХК”-ий агуулах, дахин боловсруулах үйлдвэрт хүргэнэ.

5.2. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 10-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.

Хуудас **2**

5.3. Үүсгэгч аюултай хог хаягдлаа “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлэн Хүлээн авагчид хүргэж өгнө.

5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч тал хүлээн авна.

5.5. Аюултай хог хаягдал нь гэрээний 4.2.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авагч хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд Аюултай хог хаягдлыг үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг үүсгэгч тал хариуцна.

## ЗУРГАА. ӨМЧЛӨХ ЭРХ ШИЛЖИХ

6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.

6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.

6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

## ДОЛОО. ХАРИУЦЛАГА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.

7.2. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.4-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.

7.3. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй байна.

7.4. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг иргэний хуулиар зохицуулна.

7.5. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлснээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.

7.6. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.

8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.

8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойших эрсдэлийг хүлээн авагч хариуцна.

Хуудас 3

## ЕС. БУСАД ЗҮЙЛ

9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.3. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Үүсгэгч тал 1 хувь, Хүлээн авагч тал 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**ҮҮСГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:**

Бор-Өндөр УБҮ-ийн
АБЭХХҮ мэргэжилтэн

Г.Одонтунгалаг

Утас: 88745667

Регистер: 2550466

Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: 001049

Хаяг: Хэнтий аймаг, Бор-Өндөр сум

Email хаяг: mrtsm.borundur@gmail.com

**ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:**

“Экоминерал Трейд” ХХК-ийн менежер

/О.Батхишиг/

Утас: 70179599, 94996599

Регистер: [illegible]

Тусгай зөвшөөрлийн дугаар: 0000006

Аюултай хог хаягдал тээвэрлэх, дахин боловсруулагчийн бүртгэлийн дугаар: №001125

Хаяг: УБ хот, Баянзүрх дүүрэг, 25 хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 83/2, UB Tower plus 1002 тоот.

Email хаяг: recycling@ecomineral.mn

Хуудас 4

БАТЛАВ. “ТҮМЭН-ЭГШИГ” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Г.ЧИНЗОРИГ

“....” ........ " 2022 он

БАТЛАВ. “БОР-ӨНДӨР” УБҮ-ИЙН ЗАХИРАЛ

Б.МАГСАРЖАВ

“......” ........ " 2022 он

## ХИМИЙН БОДИСЫН ХАЯГДАЛ, САВ, БАГЛАА БООДОЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ.

Гэрээ № 84-2022-02-02

2022 оны 02 сарын 11 -ны өдөр Бор-Өндөр сум

Нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 14-р хороо, Намъянжу-44 “Түмэн-Эгшиг” ХХК /цаашид Хүлээн авагч гэх/-ийн Үйлдвэр эрхэлсэн ерөнхий менежер албан тушаалтай Батмөнхийн Одбаяр, Нөгөө талаас “Монголросцветмет” ТӨҮГ-ын харъяа “Бор-Өндөр” УБҮ /цаашид Шилжүүлэгч гэх/-ийг төлөөлж Аюултай болон энгийн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн Галийн Одонтунгалаг нар Шилжүүлэгчийн үйл ажиллагааны явцад чанарын шаардлага хангахааргүй болсон химийн бодис, үлдэгдэл, сав баглаа боодлыг (цаашид хог хаягдал гэх) “Түмэн-Эгшиг” ХХК-ийн хадгалах байгууламжинд шилжүүлэхээр харилцан тохиролцож энэхүү гэрээг доорхи нөхцлөөр байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Гэрээ байгуулагч талууд нь 2017 онд шинэчлэн батлагдсан Монгол улсын “Хог хаягдлын тухай” хууль, холбогдох дүрэм, журмыг удирдлага болгон энэхүү гэрээг байгуулсан ба үйл ажиллагаандаа дагаж мөрдөх.

1.2 Шилжүүлэгчийн зүгээс Хүлээн авагчид энэхүү гэрээгээр чанарын шаардлага хангахааргүй болсон химийн бодис, сав баглаа боодлын хаягдлыг шилжүүлснээр Хүлээн авагч нь хог хаягдлыг зориулалтын аюулгүй байгууламжид хадгалж, цаашид ахуйн эргэлтэнд оруулахгүй байх.

### ХОЁР. ХҮЛЭЭН АВАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Хүлээн авагч нь энэхүү гэрээний 1.1-д заасан хууль тогтоомж, Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар бүхий хамтарсан тушаалаар баталсан “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ыг мөрдлөг болгон ажиллана.

2.2 Хүлээн авагч нь химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахтай холбоотой холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авсан байна.

2.3 Хүлээн авагч хог хаягдлыг хүлээн авч, ачаа буулгах ажлыг бүрэн хариуцна.

2.4 Хүлээн авсан хог хаягдлыг химийн бодисын хаягдал, сав, баглаа боодлыг хадгалах шаардлага хангасан аюулгүй байгууламж, агуулахад байршуулах бөгөөд хог хаягдлыг цаашид ахуйн эргэлтэнд оруулахгүй байх үүрэг хүлээнэ.

2.5 Хог хаягдлыг өмчлөх эрх, хариуцлагыг шилжүүлэн авсан тухайгаа аюултай хаягдлын улсын бүртгэлд бүртгүүлнэ.

2.6 Хүлээн авагч нь шилжүүлэгчээс хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хүлээн авна.

2.7 Хүлээн авагчийн буруутай үйл ажиллагаанаас болж гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд хүлээн авагч хохирлыг бүрэн хариуцаж төлж барагдуулах үүрэгтэй.

## ГУРАВ. ШИЛЖҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ.

3.1 Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ыг мөрдлөг болгон ажиллана.

3.2 Шилжүүлэгч нь хүлээлгэн өгөх хог хаягдлыг дээрх журмын дагуу сав, баглаа боодол, хаяг, шошготой бэлтгэн хүлээлгэж өгнө.

3.3 Шилжүүлэгч нь хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсхүл chemicalwasterisk@gmail.com хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.

3.4 Болзошгүй аюул, ослын үед ашиглах зориулалтын бүрэн ажиллагаатай гал унтраах анхан шатны багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмалыг ажлын байранд байрлуулах ба химийн бодистой харьцах ажиллагсдыг арьс, нүд болон амьсгал хамгаалах зориулалт бүхий, стандартын шаардлага хангасан хамгаалалтын хэрэгслээр хангасан байна.

3.5 Хүлээлгэн өгөх хог хаягдлын жагсаалтыг үйлдэн, хүлээн авагчид жагсаалтын дагуу хүлээлгэн өгнө.

## ДӨРӨВ. ТӨЛБӨР, ТООЦОО

4.1 Шилжүүлэгч нь хог хаягдлын хэмжээ, тоо ширхэгийг гэрээний хавсралт №1-д заасан төлбөр тооцооны тарифын дагуу харгалзуулан тооцож, тухайн үед шилжүүлэх аюултай хог хаягдлын төлбөрийн хэмжээ гарна.

4.2 Шилжүүлэгчээс Хүлээн авагчид төлөх төлбөрийг хог хаягдлыг хүлээлгэн өгөх бүртээ хэмжээ, нэр төрлөөс хамааруулан төлбөрийг тооцон, хүлээлгэн өгснөөс хойш ажлын 10 өдөрт багтаан Хүлээн авагчийн Худалдаа хөгжлийн банкны 499085408 тоот дансанд шилжүүлнэ.

4.3 Гэрээний хугацаанд шилжүүлэн өгөх хог хаягдлын төлбөр тооцоог тухай бүр хавсралтад тусган, энэхүү гэрээний 4.2 дахь заалтын дагуу төлбөрийг шилжүүлнэ.

4.4 Шилжүүлэгч тал нь гэрээний 4.2 дахь заалтын дагуу төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн бол үнийн дүнгийн 0,05%-тай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд тооцон Хүлээн авагчид төлж барагдуулна.

## ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА, ЦУЦЛАХ

5.1 Энэхүү гэрээ нь 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

5.2 Талууд гэрээг дүгнэж, харилцан тохиролцсоны үндсэн дээр дахин сунгах саналаа 1 сарын өмнө албан бичгээр харилцан мэдэгдэнэ.

5.3 Талууд гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, хариуцлага хүлээгээгүй тохиолдолд аль нэг талын санаачлагаар гэрээг цуцалж болно. Гэрээг цуцлах саналаа нөгөө талд 1 сарын өмнө албан бичгээр ирүүлсэн байна.

## ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

6.1 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцад зохих ёсоор гүйцэтгээгүй, эсвэл үүргийг зөрчсөн, аюулгүй байдлыг хангаагүйгээс Шилжүүлэгч гуравдагч этгээдэд хохирол учруулсан тохиолдолд гарсан зардлыг буруутай тал хариуцна.
6.2 Шилжүүлэгчээс урьдчилж гаргасан хүсэлт, захиалгын дагуу хог хаягдлыг тээвэрлэх хугацааг харилцан тохиролцож, тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.
6.3 Талуудын хооронд үл ойлголцол, маргаан гарсан тохиолдолд хэлэлцээрээр шийдвэрлэж чадахгүй нөхцөл үүсвэл хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлнэ.

## ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

7.1 Талуудын хүсэл, зоригийн гадуур, урьдчилан мэдэж арилгах боломжгүй дайн байлдаан, иргэдийн бослого хөдөлгөөн, нийтийг хамарсан өвчлөлт, бүслэлт, хориг, газар хөдлөлт, усны үер, гал түймэр, бусад байгалийн аюулт үзэгдэл зэрэг нөхцөл байдлын улмаас гэрээг биелүүлэх боломжгүй болсон бол гэрээний оролцогчид харилцан хариуцлага хүлээхгүй.

## НАЙМ. БУСАД

8.1 Гэрээг дагалдах хавсралтын хамт 2 хувь үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, гэрээнд заасан хугацаанаас мөрдөгдөж эхлэнэ.
8.2 Шилжүүлэгч хог хаягдал тээвэрлэх гэрээг Хүлээн авагчтай байгуулсан тохиолдолд химийн бодисын хаягдал, сав, баглаа боодлыг тээвэрлэхэд бэлтгэж, тээврийн хэрэгсэлд ачиж өгнө.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| “ТҮМЭН ЭГШИГ” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ: | БОР-ӨНДӨР УБҮ-ИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| ҮЙЛДВЭР ЭРХЭЛСЭН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР | АЮУЛТАЙ БОЛОН ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН |
| Б.ОДБАЯР | Г.ОДОНТУНГАЛАГ |
| УТАС: 99476667, 99990428, 88990428 | УТАС: 88745667 |
| ХАЯГ: МОНГОЛ УЛС. УЛААНБААТАР БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 14 ДҮГЭЭР ХОРОО НАМЪЯНЖҮ- 44 БАЙР 201, 203 ТООТ ӨРӨӨ | ХАЯГ: ХЭНТИЙ АЙМАГ, БОР-ӨНДӨР СУМ, ХОЛБОО-1 БАГ, ҮЙЛДВЭРИЙН ГУДАМЖ, БОР-ӨНДӨР УБҮ |

ТҮМЭН ЭРШИГ ХХК ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН САВ БАГЛАА БООДОЛ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЛБА

УЛААНБААТАР
Түмэн эгшиг ХХК

ХИМИЙН ХОРТОЙ БОДИС ХАДГАЛСАН ХАЯГДАЛ ХУВАНЦАР САВ
ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ТАРИФ

2022.2 сар

(тээврийн зардал неат тооцоогүй үнэ болно)

| № | Үйлчилгээний төрөл | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгж үнэ /төг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Химийн бодисын хаягдал хуванцар, сав, канистр /0,5л, 1л, 2,5л, 5л, 10л, | тн | 1 | 1150000 |
| 2 | Химийн хуванцар торх / 100л/ | ш | 1 | 4800 |
| 3 | Химийн хуванцар торх /200л/ | ш | 1 | 5600 |
| 4 | Химийн хуванцар IBC танк /1000л/ | ш | 1 | 20000 |
| 5 | Гялгар уут, шуудай, /25кг, 50кг, 1тн big bag шуудай/ | тн | 1 | 1250000 |
| 6 | Төмөр торх боошиг | ш | 1 | 4200 |
| 7 | Химйин бодисийн шил,сав | кг | 1 | 1500 |
| 8 | Капель,Тигл шаазан сав | кг | 1 | 1600 |
| 9 | Химийн хаягдал шингэн уусмал 1литр | л | 1 | 3500-4500 |
| 10 | Хаягдал аккумлятор | ш | 1 | 3000 |
| 11 | Масло шүүр том оврийн | ш | 1 | 3800 |
| 12 | Принтер хор | ш | 1 | 2500 |
| 13 | Хаягдал агаар шүүгч филтэр | ш | 1 | 4000 |
| 14 | Хаягдал лаг | Тн | 1 | 950000 |
| 15 | Хаягдал цаас | кг | | 400 |
| 16 | Хаягдал маск болон бээлий нийлэг материал | кг | 1 | 1500 |
| 17 | Хаягдал шингээгч даавуу химийн бодистой | кг | 1 | 3500 |
| 18 | Хаягдал төмөр материал болон бусад | кг | 1 | 2500 |
| 19 | Хаягдал лааз сав | ш | 1 | 1100 |
| 20 | Хаягдал баттарей | кг | 1 | 3500 |
| 21 | Ашигласан масло тос | 1 литр | 1 | 500 |
| 22 | Хөргөлтийн шингэн тосол | 1 литр | 1 | 1000 |
| 23 | Галын хорны баллон том жижиг/дунд | 1ш | 1 | 3500-4800 |
| 24 | Бохирдсон хөрс тостой | тонн | 1 | 1600000 |
| 25 | Эмнэлгийн хаягдал | Кг | 1 | 5500 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 26 | Хаягдал аккумлятор | Ш | 1 | 3500 |
| 27 | Хаягдал Battery | Кг | 1 | 1800 |
| 28 | Хаягдал дугуй /том/ | Ш | 1 | 12000-25000 |
| 29 | | | | |
| 30 | | | | |

**Тайлбар:**

Хамтын ажиллагаанд талархал илэрхийлж, амжилт хүсье.

ТҮМЭН ЭГШИГ ХХК
ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛГАЙ БОДИСЫН САВ БАГЛАА БООДОЛ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР
ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЛБА
МАРКЕТИНГИЙН АЛБА

БАТЛАВ:
“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН
ХАРЪЯА "БОР-ӨНДӨР" УБҮ-ИЙН
ЗАХИРАЛ

Б.МАГСАРЖАВ

“.......... ........” 2022 он

ХАЯГДАЛ ТӨМӨР, ХАЯГДАЛ ШИРЭМ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

№ БИ-2022-01-53

2022 оны 10 сарын 04 –ны өдөр Бор-Өндөр УБҮ

Нэг талаас “Монголросцветмет” ТӨҮГ-ын харъяа Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэр /цаашид “Худалдагч тал” гэх/-ийг төлөөлж Аюултай болон энгийн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн Г.Одонтунгалаг, нөгөө талаас Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын иргэн М.Баттулга /цаашид “Худалдан авагч” гэх/ нар харилцан тохиролцож Иргэний хуулийн 243-261-р зүйл, “Монголросцветмет” ТӨҮГ-ын 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн Техникийн зөвлөлийн хурлын тэмдэглэлийн №32-11-2 дахь заалтыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээгээр Худалдагч тал өөрийн үйл ажиллагаанд хэрэгцээгүй, цаашид ашиглах боломжгүй, актлагдсан хаягдал төмөр, ширэм худалдан авагч талд нийлүүлэх, худалдан борлуулах харилцааг зохицуулна.

Хоёр. Худалдагч талын эрх, үүрэг

2.1 Худалдагч тал өөрийн үйл ажиллагаанд хэрэгцээгүй, цаашид ашиглах боломжгүй болж актлагдсан хаягдал төмөр, ширэм Худалдан авагч талд хүлээлгэн өгч баримтаар баталгаажуулна.

2.2 Нийлүүлэх хаягдал төмөр, эд анги, хийцүүд нь ямар нэгэн өнгөт металын хольцгүй, тэсэрч дэлбэрэх зүйл агуулаагүй байна.

2.3 Хаягдал төмөр, ширэм ачилт хийгдэх үед худалдагч болон худалдан авагч тал хяналт тавина.

2.4 Хаягдал төмөр, ширэм УБҮ-ийн Уулын цехийн Барилгын хэсгийн хашаанаас гаргахдаа Худалдан авагч талын төлөөлөгчийг байлцуулан УБҮ-ийн автопүүгээр пүүлж, пүүний бичгээр баталгаажуулна.

Гурав. Худалдан авагч талын эрх, үүрэг

3.1 Энэхүү гэрээний шаардлагад нийцсэн хаягдал төмөр, ширэм худалдан авагч тал өөрийн хүн хүч, техник /автокран, авто ачигч/, тээврийн хэрэгслээр ачиж тээвэрлэнэ.

3.2 Худалдан авагч тал хаягдал төмөр таслах, огтлох, тайрах, тээвэрлэх, ачих, буулгах үеийн бүх зардлыг бүрэн хариуцна. Хэрэв Худалдагч талаас туслалцаа авсан тохиолдолд ачилтын зардлыг гадны байгууллагад үйлчилгээ үзүүлдэг техникийн үйлчилгээний тарифаар тооцож, гарсан зардлыг худалдан авагч тал бүрэн хариуцна.

3.3 ХАБЭА-н зааварчилгааг Худалдагч тал өгөх бөгөөд Худалдан авагч тал аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллана.

3.4 Хаягдал төмөр, ширэм авахдаа голж, шилэхгүй бүгдийг цэвэрлэн ачиж авах.

Дөрөв. Төлбөрийн нөхцөл

4.1 Нийлүүлэх хаягдал төмрийн үнэ нэг тонн нь 220,000 /хоёр зуун хорин мянга/ төгрөг, ширэмний үнэ нэг тонн нь 100,000 /нэг зуун мянга/ төгрөг байна.

4.3 Хаягдал төмөр, ширэмний үнийг машинд ачилт хийж пүүгээр баталгаажуулснаар гэрээнд заасан үнийн дүнг Худалдагч талын Хаан банкны 5946025683 тоот дансанд эсвэл УБҮ-ийн кассанд бэлнээр тушааж, төлбөр тооцоог хийж дуусгаснаар УБҮ-ийн постоор гаргана.

4.4 Хаягдал төмөр, ширэмний үнийг төлөөгүй нөхцөлд худалдан авагчид барааг нийлүүлэхгүй бөгөөд зээлээр худалдан борлуулахгүй.

4.5 Хаягдал төмөр, ширэм худалдах, худалдан авах хугацааг 2022 оны ..... сарын ..... өдрөөс 2022 оны ..... сарын ..... өдрийг дуустал 1 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ.

4.6 Хаягдал төмөр, ширэмний нийлүүлэгдэх хэмжээ хаягдал төмөр 456 тонн, ширэм 7 тонноос доошгүй байна.

Тав. Бусад

5.1 Хаягдал төмрийг ачиж, УБҮ-ийн автопүүгээр пүүлснээр 2 талаас тооцоо нийлсэн Акт үйлдэнэ.

5.2 Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний үүрэг биелэгдсэнээр дуусгавар болно. Гэрээг 2 хувь үйлдэнэ.

5.3 Энэхүү гэрээнд орох аливаа өөрчлөлтийг талууд харилцан зөвшилцөж, тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдэж оруулна. Талууд дангаараа гэрээнд өөрчлөлт оруулахгүй.

5.4 Энэхүү гэрээ байгуулагдснаар талуудын хооронд байгуулсан 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн BU-2022-01-52 дугаартай “Хаягдал төмөр, хаягдал ширэм, хаягдал ган хоолой худалдах, худалдан авах гэрээ”-г хүчингүй болсонд тооцно.

6. Хариуцлага

6.1 Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс аль нэг талд учирсан хохирлыг буруутай тал нь төлж барагдуулна.

6.2 Гэрээ баталгаажсан өдрөөс хойш 10 хоногийн дотор худалдан авалт хийгээгүй тохиолдолд Худалдагч тал дангаараа гэрээг цуцлана.

6.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| “ХУДАЛДАГЧ ТАЛ”-ийг төлөөлж:<br>УБҮ-ИЙН АЮУЛТАЙ БОЛОН ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН | “ХУДАЛДАН АВАГЧ” талыг төлөөлж<br>ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН 2-Р БАГ ХОЛБОО 44 БАЙР 56 ТООТОД ОРШИН СУУГЧ |
| Г.ОДОНТУНГАЛАГ | М.БАТТУЛГА |
| УТАС: 88745667 | УТАС: 80258030 |

ТАНИЛЦСАН:

БОР-ӨНДӨР УБҮ-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

.................................... П.МАШБАТ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

.................................... Б.МӨНХБАЯР

ТЭЗСХ-ИЙН ДАРГА

.................................... Б.ГЭРЭЛТУЯА

ЗХ-ИЙН ДАРГЫН Ү.Г

.................................... Ц.АНХБАЯР

ЗХ-ИЙН ХНАХ МЭРГЭЖИЛТЭН-ХУУЛЬЧ

.................................... Г.ЭНХЖАРГАЛ

ДОТООД ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН

.................................... С.БАКЫТХАН

БАТЛАВ.
УЦУОШТ-ИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ХЭРЛЭНЧИМЭГ

2022 он ..06.... сар ..17... өдөр

ЗӨВШӨӨРСӨН.
БОР-ӨНДӨР УБҮ-ИЙН
ЗАХИРАЛ

Б.МАГСАРЖАВ

2022 он ..6.. сар ..20.. өдөр

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№ БӨ-2022-03-13.

2022 он 06 сар 21 өдөр Чингис хот

Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон энэхүү гэрээг нэг талаас захиалагчийг төлөөлж “Монголросцветмет” ТӨҮГ-ын харъяа “Бор-Өндөр” УБҮ-ийн Байгаль орчин, нөхөн сэргээлт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Мөнххүлэг /цаашид захиалагч гэх/, нөгөө талаас Хэнтий аймгийн УЦУОШТөвийн БОШЛ-ын эрхлэгч, инженер Б.Ганганбайгал /цаашид гүйцэтгэгч гэх/ нар харилцан тохиролцож байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

1.1. Гүйцэтгэгч байгууллага нь захиалагч байгууллагын хүсэлтээр 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу орчны шинжилгээний дээжийг авна.

1.2. Гүйцэтгэгч байгууллага нь дараахи үзүүлэлтээр шинжилгээг хийж дурьдсан хугацаанд үр дүнг хүргүүлнэ.

| Дээжийн нэр | Үзүүлэлтүүд | Тодорхойлох арга | Хяналтын цэгийн тоо |
|---|---|---|---|
| Агаарын чанар | Хүхэрлэг хий (SO2) | 20 минут автомат анализатор | 12 |
| | Азотын давхар исэл (NO2) | 20 минут автомат анализатор | |
| | Тоосонцор $PM_{10}$ | 24 цаг автомат анализотор | 4 |
| | Тоосонцор $PM_{2.5}$ | 24 цаг автомат анализотор | |
| Хөрсний чанар | Хими чанар | Тооцооны болон бусад аргууд | 9 |
| Усны чанар | Хими чанар | Тооцооны болон | 12 |

| | | | |
|---|---|---|---|
| | | бусад аргууд | |
| Цацраг | Тунгийн түвшин хэмжих | Шууд хэмжлийн багажаар | 8 |
| Бэлчээрийн ургамлан нөмрөг | Төлөв байдал | Шугман цэгийн болон үнэлгээний аргаар | 4 |

1.3. Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үнэлгээг БОАЖЯ-ны сайдын 2019 оны 05.06 өдрийн А/164 тоот тушаалаар батлагдсан журмыг баримтлан тогтооно.

А. Агаарын чанар

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Хүхэрлэг хий (SO2) | 12500 |
| 2 | Азотын давхар исэл (NO2) | 12500 |
| | Нийт | 25000 |

Б. Агаар дахь тоосонцорын хэмжээ

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Тоосонцор $PM_{10}$ | 25000 |
| 2 | Тоосонцор $PM_{2,5}$ | 25000 |
| | Нийт | 50000 |

В. Хөрсний чанар

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Анхан шатны боловсруулалт | 8000 |
| 2 | Урвалын орчин /pH/ | 3000 |
| 3 | Чийг | 6500 |
| 4 | Ялзмаг | 10500 |
| 5 | Аммоний азот (NH4) | 8900 |
| 6 | Нитратын азот (NO3) | 8500 |
| 7 | Сульфатын ион (SO4) | 5500 |
| 8 | Эрдэс фосфор (PO4) | 6000 |
| Нийт | | 56900 |

Г. Усны чанар

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Усан орчин /pH/ | 1500 |
| 2 | Цахилгаан дамжуулах чанар /Ec/ | 1500 |
| 3 | Жинлэгдсэн бодис | 5000 |
| 4 | Уусан хүчилтөрөгч | 3500 |
| 5 | Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч | 17000 |
| 6 | Перманганатын исэлдэх чанар | 5500 |

| | | |
|---|---|---|
| 7 | Хатуулаг | 1500 |
| 8 | Кальцийн ион | 1500 |
| 9 | Магнийн ион | 1000 |
| 10 | Натри+Калийн ион | 1000 |
| 11 | Гидрокарбонатын ион | 2500 |
| 12 | Хлорын ион | 2500 |
| 13 | Сульфатын ион | 3500 |
| 14 | Эрдэсжилт | 1500 |
| 15 | Аммонийн азот | 3500 |
| 16 | Нитритийн азот | 3000 |
| 17 | Нитратын азот | 4000 |
| 18 | Эрдэс фосфор | 2500 |
| 19 | Төмөр | 2500 |
| 20 | Фтор | 2500 |
| Нийт | | 65500 |

Д. Бэлчээрийн нөмрөг, төлөв байдлын ажиглалт

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Бэлчээрийн ургамлын голлох зүйлийн бүрдэл | 25000 |
| 2 | Бэлчээрийн ургамлын бүрхэцийн хэмжээ | 10000 |
| 3 | Бэлчээрийн ургамлын өндөр, ургац | 25000 |
| 4 | Бэлчээрийн талхлагдалт, хөрсний элэгдэл эвдрэлийн үнэлгээ | 15000 |
| 5 | Дүгнэлт | 15000 |
| Нийт | | 90000 |

Ж. Цацраг

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Цацрагийн тунгийн түвшин хэмжих | 5000 |

1.4. Гэрээний хугацаа

- Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа- 2022 оны __ дугаар сар
- Ажил эхлэх хугацаа - 2022 оны __ дугаар сар ___
- Ажил дуусах хугацаа- 2022 оны __ дугаар сар ___

2. Захиалагчийн эрх үүрэг

2.1. Захиалагч нь ажил гүйцэтгэхэд шаардагдах нөхцөлийг бүрдүүлж өгнө. Үүнд:

- Шинжилгээний сорьц авах объект нь УЦУОШТ-ны БОШЛ-аас 5 км-с хол зайд байрладаг бол унаагаар хангах.
- Сорьц авах шаардлагатай бүс газарт саадгүй нэвтрүүлэх
- Сорьц авах багаж, төхөөрөмжийг ажиллуулахад шаардлагатай цахилгааны эх үүсвэрээр хангах

2.2. Хөдөө орон нутагт ажиллах бол ажиллах хугацааны унаа, хоол, байрны зардлыг бүрэн хариуцна.

2.3. Дээж авах үед ажилтны хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн дэглэмийг баримталж аюулгүй ажиллагааны зөвлөгөө, хамгаалах хувцас, хэрэглэлээр хангах.

2.4. Гүйцэтгэгч хүссэн тохиолдолд шинжилгээ хийлгэх объектийн талаархи мэдээлэл өгөх.

2.5. Гүйцэтгэгчийн ажил үйлчилгээний явцад хяналт тавих

2.6. Захиалагч байгууллага гэрээ байгуулсаны дараа ажил эхлэхийн өмнө шинжилгээний үнэ, ажиллах ажилтны унаа, томилолтын зардлыг бүрэн шилжүүлсэн байна.

3. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

3.1. Тухайн байгууллагын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу сорьц авч шинжилгээ хийнэ.

3.2. Сорьц авч, шинжилгээ хийх ажлыг мэргэжлийн ажилтнаар биечлэн гүйцэтгүүлнэ.

3.3. Сорилын дүнг гэрээнд заасан хугацаанд захиалагчид гаргаж өгөх

3.4. Сорьц авах объектэд ажиллах нөхцөл, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн шаардлага хангахыг шаардах

3.5. Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

3.6. Захиалагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалж захиалагчид учирсан хохирлыг гүйцэтгэгч хариуцахгүй.

4. Ажлын хөлс, төлбөр тооцоо

4.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын нэгж объетоос дээж авч шинжилгээ хийсний нийт төлбөр болох 2.378.100 төгрөг /үсгээр/ *Хоёр сая гурван зуун далан найман мянга нэг зуу/* байна.

*Шинжилгээний дээж авах байршлын тоо, үнэлгээ /Урьдчилсан байдлаар/*

| № | Шинжилгээний сорьц авах байршил /Хаяг/ | Шинжилгээний сорьцийн тоо | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Ус | Хөрс | Агаар | Цацраг | Тоосон цор | Бэлчээрийн ургамлан нөмрөг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бор-Өндөр УБҮ | 8 | 7 | 10 | 6 | 3 | 4 |
| 2 | Баргилтын уурхай | 4 | 2 | 2 | 2 | 1 | 2 |
| Нийт тоо | | 12 | 9 | 12 | 8 | 4 | 6 |
| Үнэ /төгрөг/ | Нэгж | 65.500 | 56.900 | 25.000 | 5000 | 50.000 | 90.000 |
| | Бүгд | 786.000 | 512.100 | 300.000 | 40000 | 200.000 | 540.000 |

Дүн- 2.378.100 төгрөг

4.2. Ажил гүйцэтгэсний төлбөр 2.378.100 төгрөг /үсгээр/ *Хоёр сая гурван зуун далан найман мянга нэг зуу/* төгрөг 2022 оны 06 дугаар сарын 20-ны дотор манай байгууллагын Төрийн сан банк 100180013015 тоот дансанд шилжүүлсэн байна.

4.3. Гүйцэтгэгч ажилтанд гэрээгээр ажил гүйцэтгэх хөлс 700.000 */Долоон зуун мянган төгрөг/*-ийг /Хавсралтан заасны дагуу/ захиалагч тал манай байгууллагын Төрийн сан банк 100180013402 тоот дансанд шилжүүлсэн байна.

4.4. Гэрээт ажлын шатахууны зардал /нэг талын/ 150.920 /*Нэг зуун тавин мянга есөн зуун хорин* / төгрөгийг Хэнтий аймаг ПЕТРОВИС ХХК-ын ХААН банк-5750691575 дансанд “*УЦУОШТ-ийн шинжилгээний шатахуун*” утгаар бэлэн бусаар шилжүүлнэ. Буцах шатахууныг

4.5. тооцоогүй.

5. Талуудын хүлээх хариуцлага

5.1. Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацааг хэтрүүлсэн хоног тутамд 0.05 хувийн алданги төлнө.

5.2. Захиалагч төлбөрөө гэрээнд заасан хугацаанаас хэтрүүлсэн хоног тутамд 0.05 хувийн алданги төлнө.

5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүргэтэй.

5.4. Гэрээг 2 хувь үйлдэх ба талууд 1 хувийг хадгална.

6. Бусад заалт

6.1. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

6.3. Талуудын хоорондын маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүй хүрвэл /шүүх арбитр/-аар шийдвэрлүүлнэ.

7. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам

Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| ХЭНТИЙ АЙМГИЙН УЦУОШТ-ИЙН БОШЛ-ЫН ЭРХЛЭГЧ, ИНЖЕНЕР | БОР-ӨНДӨР УБҮ-ИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НӨХӨН СЭРГЭЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН |
| Б.ГАНГАНБАЙГАЛ | Б.МӨНХХҮЛЭГ |
| ХАЯГ:<br>ХЭРЛЭН СУМ 2 БАГ<br>ТЭМҮҮЖИНГИЙН ГУДАМЖ<br>Н-13 | ХАЯГ:<br>ХЭНТИЙ БОР-ӨНДӨР СУМ<br>1-Р БАГ, ҮЙЛДВЭРИЙН<br>ГУДАМЖ |
| УТАС: 98092200, 93028633 | УТАС: 85000111, 880898194 |

ТАНИЛЦСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР ..............................

ЗХ-ИЙН ДАРГА ..............................

ЕРӨНХИЙ НЯ-БО ..............................

ТЭЗСХ-ИЙН ДАРГА ..............................

Ажил гүйцэтгэх .................... тоот
Гэрээний хавсралт №1

1. Гэрээт ажлын хөлс

| № | Ажилтаны нэр | Албан тушаал | Үйл ажиллагааны чиглэл | Хоног | Томилолт ₮ | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1 хоног | Нийт |
| 1 | Б.Ганганбайгал | БОШЛ-ийн эрхлэгч, инженер | Ус, хөрс, агаарын шинжилгээ | 4 | 35000 | 140000 |
| 2 | Б.Шүрэнцэцэг | БОШЛ-ын инженер | Ус, хөрс, агаарын шинжилгээ | 4 | 35000 | 140000 |
| 3 | Ч.Уранчимэг | ХААЦУ-ын инженер | Бэлчээрийн ажиглалт | 4 | 35000 | 140000 |
| 4 | Д.Ариунтуяа | ХААЦУ-ын судалгааны инженер | Бэлчээрийн ажиглалт | 4 | 35000 | 140000 |
| 5 | Д. Ганзориг | УЦУОШТ-ын жолооч | Жолооч | 4 | 35000 | 140000 |
| | Нийт | | | | 700000 төгрөг | |

2. Шатахууны зардал /Очих шатахуун/

| № | Маршрут | | Зай /км/ | Шатахууны хэмжээ | | Шатахууны үнэ ₮ | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хаанаас | Хаана | | норм | Нийт | Нэгжийн үнэ ₮ | Нийт үнэ ₮ |
| 1 | Чингис хот | Бор өндөр | 200 | 22 | 44 | 3430 | 150.920 |
| | Нийт | | 200 | | | 150.920 төгрөг | |

БАТЛАВ:
ХЭНТИЙ АЙМГИЙН УЦУОШТ-ИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ХЭРЛЭНЧИМЭГ

2022 он ..... сар ..... өдөр

ЗӨВШӨӨРСӨН:
БОР- ӨНДӨР УБҮ-ИЙН
ЗАХИРАЛ
Б.МАГСАРЖАВ

2022 он ..... сар ..... өдөр

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№ БӨ-2022-03-22

2022 он 03 сар 22 өдөр Чингис хот

Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон энэхүү гэрээг нэг талаас захиалагчийг төлөөлж “Монголросцветмет” ТӨҮГ-ын харъяа “Бор-Өндөр” УБҮ-ийн Байгаль орчин, нөхөн сэргээлт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Мөнххүлэг /цаашид захиалагч гэх/, нөгөө талаас Хэнтий аймгийн УЦУОШТөвийн БОШЛ-ын эрхлэгч, инженер Б.Ганганбайгал /цаашид гүйцэтгэгч гэх/ нар харилцан тохиролцож байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

1.1. Гүйцэтгэгч байгууллага нь захиалагч байгууллагын хүсэлтээр 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу орчны шинжилгээний дээжийг авна.

1.2. Гүйцэтгэгч байгууллага нь дараахи үзүүлэлтээр шинжилгээг хийж дурьдсан хугацаанд үр дүнг хүргүүлнэ.

| Дээжийн нэр | Үзүүлэлтүүд | Тодорхойлох арга | Хяналтын цэгийн тоо |
|---|---|---|---|
| Агаарын чанар | Хүхэрлэг хий ($SO_2$) | 20 минут автомат анализатор | 12 |
| | Азотын давхар исэл ($NO_2$) | 20 минут автомат анализатор | |
| | Тоосонцор $PM_{10}$ | 24 цаг автомат анализотор | 4 |
| | Тоосонцор $PM_{2,5}$ | 24 цаг автомат анализотор | |
| Хөрсний чанар | Хими чанар | Тооцооны болон бусад аргууд | 9 |

| | | | |
|---|---|---|---|
| Усны чанар | Хими чанар | Тооцооны болон бусад аргууд | 12 |
| Цацраг | Тунгийн түвшин хэмжих | Шууд хэмжлийн багажаар | 8 |
| Бэлчээрийн ургамлан нөмрөг | Төлөв байдал | Шугман цэгийн болон үнэлгээний аргаар | 4 |

1.3. Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үнэлгээг БОАЖЯ-ны сайдын 2019 оны 05 сарын 06-ны өдрийн А/164 тоот тушаалаар батлагдсан журмыг баримтлан тогтооно.

А. Агаарын чанар

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Хүхэрлэг хий ($SO_2$) | 12500 |
| 2 | Азотын давхар исэл ($NO_2$) | 12500 |
| | Нийт | 25000 |

Б. Агаар дахь тоосонцорын хэмжээ

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Тоосонцор $PM_{10}$ | 25000 |
| 2 | Тоосонцор $PM_{2,5}$ | 25000 |
| | Нийт | 50000 |

В. Хөрсний чанар

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Анхан шатны боловсруулалт | 8000 |
| 2 | Урвалын орчин /pH/ | 3000 |
| 3 | Чийг | 6500 |
| 4 | Ялзмаг | 10500 |
| 5 | Аммоний азот ($NH_4$) | 8900 |
| 6 | Нитратын азот ($NO_3$) | 8500 |
| 7 | Сульфатын ион ($SO_4$) | 5500 |
| 8 | Эрдэс фосфор ($PO_4$) | 6000 |
| Нийт | | 56900 |

Г. Усны чанар

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Усан орчин /pH/ | 1500 |
| 2 | Цахилгаан дамжуулах чанар /Ec/ | 1500 |
| 3 | Жинлэгдсэн бодис | 5000 |
| 4 | Уусан хүчилтөрөгч | 3500 |

| | | |
|---|---|---|
| 5 | Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч | 17000 |
| 6 | Перманганатын исэлдэх чанар | 5500 |
| 7 | Хатуулаг | 1500 |
| 8 | Кальцийн ион | 1500 |
| 9 | Магнийн ион | 1000 |
| 10 | Натри+Калийн ион | 1000 |
| 11 | Гидрокарбонатын ион | 2500 |
| 12 | Хлорын ион | 2500 |
| 13 | Сульфатын ион | 3500 |
| 14 | Эрдэсжилт | 1500 |
| 15 | Аммонийн азот | 3500 |
| 16 | Нитритийн азот | 3000 |
| 17 | Нитратын азот | 4000 |
| 18 | Эрдэс фосфор | 2500 |
| 19 | Төмөр | 2500 |
| 20 | Фтор | 2500 |
| Нийт | | 65500 |

Д. Бэлчээрийн нөмрөг, төлөв байдлын ажиглалт

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Бэлчээрийн ургамлын голлох зүйлийн бүрдэл | 25000 |
| 2 | Бэлчээрийн ургамлын бүрхэцийн хэмжээ | 10000 |
| 3 | Бэлчээрийн ургамлын өндөр, ургац | 25000 |
| 4 | Бэлчээрийн талхлагдалт, хөрсний элэгдэл эвдрэлийн үнэлгээ | 15000 |
| 5 | Дүгнэлт | 15000 |
| Нийт | | 90000 |

Ж. Цацраг

| № | Тодорхойлох үзүүлэлт | Үнэ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Цацрагийн тунгийн түвшин хэмжих | 5000 |

1.4. Гэрээний хугацаа

- Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа- 2022 оны 09 дүгээр сар
- Ажил эхлэх хугацаа - 2022 оны .... дүгээр сарын .... ны өдөр
- Ажил дуусах хугацаа- 2022 оны .... дүгээр сарын .... –ны өдөр

2. Захиалагчийн эрх үүрэг

2.1. Захиалагч нь ажил гүйцэтгэхэд шаардагдах нөхцөлийг бүрдүүлж өгнө. Үүнд:

- Шинжилгээний сорьц авах объект нь УЦУОШТ-ны БОШЛ-аас 5 км-с хол зайд байрладаг бол унаагаар хангах.

- Сорьц авах шаардлагатай бүс газарт саадгүй нэвтрүүлэх
- Сорьц авах багаж, төхөөрөмжийг ажиллуулахад шаардлагатай цахилгааны эх үүсвэрээр хангах

2.2. Хөдөө орон нутагт ажиллах бол ажиллах хугацааны унаа, хоол, байрны зардлыг бүрэн хариуцна.

2.3. Дээж авах үед ажилтны хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн дэглэмийг баримталж аюулгүй ажиллагааны зөвлөгөө, хамгаалах хувцас, хэрэглэлээр хангах.

2.4. Гүйцэтгэгч хүссэн тохиолдолд шинжилгээ хийлгэх объектийн талаархи мэдээлэл өгөх.

2.5. Гүйцэтгэгчийн ажил үйлчилгээний явцад хяналт тавих

2.6. Захиалагч байгууллага гэрээ байгуулсаны дараа ажил эхлэхийн өмнө шинжилгээний үнэ, ажиллах ажилтны унаа, томилолтын зардлыг бүрэн шилжүүлсэн байна.

3. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

3.1. Тухайн байгууллагын 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу сорьц авч шинжилгээ хийнэ.

3.2. Сорьц авч, шинжилгээ хийх ажлыг мэргэжлийн ажилтнаар биечлэн гүйцэтгүүлнэ.

3.3. Сорилын дүнг гэрээнд заасан хугацаанд захиалагчид гаргаж өгөх

3.4. Сорьц авах объектэд ажиллах нөхцөл, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн шаардлага хангахыг шаардах

3.5. Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

3.6. Захиалагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалж захиалагчид учирсан хохирлыг гүйцэтгэгч хариуцахгүй.

4. Ажлын хөлс, төлбөр тооцоо

4.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын нэгж объетоос дээж авч шинжилгээ хийсний нийт төлбөр болох 2,378,100 төгрөг /үсгээр/ *Хоёр сая гурван зуун далан найман мянга нэг зуу/* байна.

*Шинжилгээний дээж авах байршлын тоо, үнэлгээ /Урьдчилсан байдлаар/*

| № | Шинжилгээний сорьц авах байршил /Хаяг/ | | Шинжилгээний сорьцийн тоо | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ус | Хөрс | Агаар | Цацраг | Тоосонцор | Бэлчээрийн ургамлан нөмрөг |
| 1 | Бор-Өндөр УБҮ | | 8 | 7 | 10 | 6 | 3 | 4 |
| 2 | Баргилтын уурхай | | 4 | 2 | 2 | 2 | 1 | 2 |
| Нийт тоо | | | 12 | 9 | 12 | 8 | 4 | 6 |
| Үнэ /төгрөг/ | | Нэгж | 65.500 | 56.900 | 25.000 | 5000 | 50.000 | 90.000 |
| | | Бүгд | 786.000 | 512.100 | 300.000 | 40000 | 200.000 | 540.000 |

Дүн- 2.378.100 төгрөг

4.2. Ажил гүйцэтгэсний төлбөр 2.378.100 төгрөг /үсгээр/ *Хоёр сая гурван зуун далан найман мянга нэг зуу/* төгрөг 2022 оны 09 дүгээр сарын 26-ны дотор манай байгууллагын Төрийн сан банк 100180013015 тоот дансанд шилжүүлсэн байна.

4.3. Гүйцэтгэгч ажилтанд гэрээгээр ажил гүйцэтгэх хөлс 700.000 */Долоон зуун мянган төгрөг/*-ийг /Хавсралтан заасны дагуу/ захиалагч тал манай байгууллагын Төрийн сан банк 100180013402 тоот дансанд шилжүүлсэн байна.

***4.4.*** Гэрээт ажлын шатахууны зардал /нэг талын/ 164.120 /*Нэг зуун жаран дөрвөн мянга нэг зуун хорин*/ төгрөгийг Хэнтий аймаг “ШУНХЛАЙ ГОВЬ” ХХК-ийн ХААН банк 5107052328 дансанд “*УЦУОШТ-ийн шинжилгээний шатахуун*” утгаар бэлэн бусаар шилжүүлнэ. Буцах шатахууныг тооцоогүй.

5. Талуудын хүлээх хариуцлага

5.1. Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацааг хэтрүүлсэн хоног тутамд 0.05 хувийн алданги төлнө.

5.2. Захиалагч төлбөрөө гэрээнд заасан хугацаанаас хэтрүүлсэн хоног тутамд 0.05 хувийн алданги төлнө.

5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

5.4. Гэрээг 2 хувь үйлдэх ба талууд 1 хувийг хадгална.

6. Бусад заалт

6.1. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

6.3. Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл /шүүх арбитр/-аар шийдвэрлүүлнэ.

7. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам

Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХЭНТИЙ АЙМГИЙН
УЦУОШТ-ИЙН БОШЛ-ЫН
ЭРХЛЭГЧ, ИНЖЕНЕР

Б.ГАНГАНБАЙГАЛ

ХАЯГ:
ХЭРЛЭН СУМ 2 БАГ
ТЭМҮҮЖИНГИЙН ГУДАМЖ
Н-13

УТАС: 98092200, 93028633

БОР-ӨНДӨР УБҮ-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, НӨХӨН
СЭРГЭЭЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.МӨНХХҮЛЭГ

ХАЯГ:
ХЭНТИЙ БОР-ӨНДӨР СУМ
1-Р БАГ, ҮЙЛДВЭРИЙН
ГУДАМЖ

УТАС: 85000111, 80898194

ТАНИЛЦСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР ..............................

ЗХ-ИЙН ДАРГА ..............................

ЕРӨНХИЙ НЯ-БО ..............................

ТЭЗСХ-ИЙН ДАРГА ..............................

ЗХ-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН-ХУУЛЬЧ ..............................

Ажил гүйцэтгэх 24-2022-05-22 тоот
Гэрээний хавсралт №1

1. Гэрээт ажлын хөлс

| № | Ажилтаны нэрс | Албан тушаал | Үйл ажиллагааны чиглэл | Хоног | Томилолт /төгрөг/ | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1 хоног | Нийт /төгрөг/ |
| 1 | Б.Ганганбайгал | БОШЛ-ийн эрхлэгч, инженер | Ус, хөрс, агаарын шинжилгээ | 4 | 35000 | 140000 |
| 2 | Б.Шурэнцэцэг | БОШЛ-ын инженер | Ус, хөрс, агаарын шинжилгээ | 4 | 35000 | 140000 |
| 3 | Ч.Уранчимэг | ХААЦУ-ын инженер | Бэлчээрийн ажиглалт | 4 | 35000 | 140000 |
| 4 | Д.Ариунтуяа | ХААЦУ-ын судалгааны инженер | Бэлчээрийн ажиглалт | 4 | 35000 | 140000 |
| 5 | Д. Ганзориг | УЦУОШТ-ын жолооч | Жолооч | 4 | 35000 | 140000 |
| Нийт | | | | | | 700000 |

2. Шатахууны зардал /Очих шатахуун/

| № | Маршрут | | Зай /км/ | Шатахууны хэмжээ | | Шатахууны үнэ ₮ | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хаанаас | Хаана | | норм | Нийт | Нэгжийн үнэ ₮ | Нийт үнэ ₮ |
| 1 | Чингис хот | Бор өндөр | 200 | 22 | 44 | 3730 | 164.120 |
| 2 | Нийт | | 200 | 22 | 44 | 164.120 төгрөг | |